МОНГОЛ УЛСАД ӨНГӨТ МЕТАЛЛ БОЛОН ХАР ТӨМӨРЛӨГИЙН НЭМҮҮ ӨРТӨГ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОЛЦОО

Төсөл G/21/04

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс (GTZ) хэрэгжүүлж буй Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төслийн захиалгаар

Зөвлөх Д. Цэцэн

бэлтгэн боловсруулав

Улаанбаатар хот, 2005 оны 10 дугаар сар

АГУУЛГА

ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 4

ТАЛАРХАЛ 5

ОРШИЛ 6

Судалгааны зорилго 6
Судалгаанд хамрагдсан асуудлууд 6
Судалгааны аргачлал 7

ХУРААНГҮЙ 8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО БОЛОН МОНГОЛ УЛСЫН ӨНГӨТ МЕТАЛЛ БОЛОН ХАР ТӨМӨРЛӨГИЙН САЛБАРЫН ИРЭЭДҮЙ 10

1.1 Төрийн өнөөгийн бодлого 10
1.2 Хэрэгжилт, явцын бодит байдал 11
1.3 Идэвхгүй төр 11
1.4 “Түрүүлж ирснийг түрүүлж үйлчлэх” хэмээх зарчим 11
1.5 Орон нутгийн төр засаг 12
1.6 Уул уурхайн салбарын тулгамдсан асуудлууд 13
Нөхөн сэргээлт 13
Хайгуулын ажил 14
1.7 Хэтийн төлөв 15

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН ЭКСПОРТЫН БОЛОН ХУДАЛДААНЫ НИЙТ ХЭМЖЭЭНД ХАР БОЛОН ӨНГӨТ МЕТАЛЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ 16

2.1 Зэсийн үйлдвэрлэлийн салбар 16
Үйлдвэрлэл 16
Үйлдвэрлэгчид 18
2.2 Хар төмрийн үйлдвэрлэл 19
Үйлдвэрлэл 19
Үйлдвэрлэгчид 19
2.3 Алтны салбар 21
Үйлдвэрлэл 21
Үйлдвэрлэгчид 24
Дагалдах зах зээлийн зарим нэг асуудлууд 25
2.4 Гянт болд болон цайрын үйлдвэрлэл 26
Гянт болдын үйлдвэрлэл 26
Цайрын Үйлдвэрлэл 27

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛДВЭРҮҮД 28

3.1 Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр (Эрдэнэт Үйлдвэр) 28
Үйлдвэрлэлийн танилцуулга 28
Тулгарч байгаа бэрхшээлүүд 28
Төлөвлөгөө 29
3.2 Эрдмин үйлдвэр 31
Товч түүх 32
Тулгарч буй бэрхшээлүүд 33
Төлөвлөгөө 34

3.3 Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр (ДТҮ) 34
Төлөвлөгөө 36
3.4 Монголросцветмет нэгдэл 37
Алтны үйлдвэрлэл 38
Тулгарч буй бэрхшээлүүд 39
Төлөвлөгөө 39
3.5 Алтан Дорнод Монгол 40
Үйлдвэрлэл 40
Тулгамдсан асуудлууд 40
Төлөвлөгөө 41
3.6 Монполимет Компани 42
Алтны үйлдвэрлэл 42
Төлөвлөгөө 43
3.7 Эрдэс Компани 43
Үйлдвэрлэл 43
Тулгамдсан асуудлууд 43
3.8 Гянт болд үйлдвэрлэгчид 44
Үйлдвэрлэл 44
Төлөвлөгөө 44
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГОВЬ БОЛОН ЗҮҮН БҮСИЙН ИРЭЭДҮЙТЭЙ ШИНЭ ОРД 45
4.1 Үндсэн гол ордыг хөгжүүлэх бодлого 45
4.2 Зарим ирээдүйтэй алт, зэсийн орд 46
Оюу Толгой 46
Гацууртын орд 47
Монгол Газар компанийн төслүүд 47
Таван орд 48
ТАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД ОРНУУДЫН МЕТАЛЛЫН ЗАХ ЗЭЭЛ 49
5.1 БНХАУ-ын өнгөт болон зарим үндсэн металлын эрэлт хэрэгцээ 49
Зэсийн үйлдвэр 49
Алтны зах зээл 50
Өнгөт металлын аж үйлдвэр 51
Бусад үндсэн металл 52
ЗӨВЛӨМЖ 55
ХАВСРАЛТ 1: ЯРИЛЦЛАГА АВСАН ХҮМҮҮСИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ 57
ХАВСРАЛТ 2: АШИГЛАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ 58

ХҮСНЭГТ БА ЗУРАГ

Зураг 1: Хайгуулын лицензийн байршлын зураг 14
Хүснэгт 1: Монгол улсын уул уурхайн салбарын хөгжлийн хандлага 15
Хүснэгт 2: 1997-2004 онууд дахь зэсийн үйлдвэрлэл 16
Зураг 2: Монгол улсын зэсийн үйлдвэрлэлийг Лондонгийн металлын биржийн зэсийн үнэтэй харьцуулсан байдал, 1997-2004 онууд 17
Хүснэгт 3: Монголын зэсийн экспорт, 2000-2004 онууд 17
Хүснэгт 4: Зэсийн экспортыг үйлдвэрлэлтэй харьцуулсан нь 1997-2004 онууд 18
Хүснэгт 5: Төмөрлөг бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба экспорт 2000-2004 онууд 20
Зураг 3: Уурхай тус бүрийн нийт алт олборлолт, 2002-2004 онууд 22
Хүснэгт 6: Монгол улсын алт олборлолтын хэмжээ, 1992-2004 онууд 23
Зураг 4: Алт олборлолт, 1992-2004 онуудад 23
Хүснэгт 7: Алтны экспорт, 1999-2004 онуудад 24
Зураг 5: Алт олборлолт болон экспортын хэмжээ 24
Хүснэгт 8: Алт олборлогчдын тоо 24
Зураг 6: Алт олборлогчдын тоо, 1997-2005 онуудад 25
Хүснэгт 9: Гянт болдын хүдрийн олборлолт 27
Хүснэгт 10: Агуулга 28
Зураг 7: Эрдэнэтийн уурхай 29
Зураг 8: Стратеги төлөвлөгөөний бүдүүвч 31
Хүснэгт 11: Катодын зэсийн үйлдвэрлэлт, 1997-2004 онуудад 33
Зураг 9: Технологийн бүдүүвч 35
Хүснэгт 12: ДТҮ-ийн үйлдвэрлэлт, 2002-2005 онуудад 35
Хүснэгт 13: Хаягдал төмрийн экспорт, 2002-2005 онууд 36
Зураг 10: Хаягдал төмрийн экспорт, 2003-2005 онууд 36
Хүснэгт 14: Монголросцветмет нэгдлийн алт олборлолт 38
Хүснэгт 15: Шижир алт компанийн алт олборлолт 39
Хүснэгт 16: Алтан Дорнод Монгол компанийн алт олборлолтын хэмжээ 40
Хүснэгт 17: Алт олборлолт (Нийлбэр дүнгээр) 42
Хүснэгт 18: Зарим ашигт малтмалын нийт батлагдсан нөөц 45
Хүснэгт 19: БНХАУ-ын зэсийн үйлдвэр *(мянган тонноор)* 49
Хүснэгт 20: Зэсийн импорт *(мянган тонноор)* 50
Хүснэгт 21: БНХАУ-ын алтны зах зээл, 2000-2003 онууд 51
Хүснэгт 22: БНХАУ-ын 2000-2005 онуудын хар төмөрлөгийн үйлдвэрлэл 51
Хүснэгт 23: 2000-2004 онуудыг Хятадын цайрын зах зээл, (мянган тонноор) 53

ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Энэхүү баримт бичигт тусгагдсан аж ахуйн байгууллагуудын эд хөрөнгө болон үйл ажиллагааны талаарх мэдээлэл нууц бөгөөд зөвхөн Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс (GTZ) хэрэгжүүлж буй “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн зөвшөөрөлтэйгөөр тайланг хүлээн авсан хүмүүсийн хэрэгцээнд зориулсан болно.

Энэхүү баримт бичгийг хүлээн авсан этгээд нь “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслөөс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр баримт бичгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн олшруулах буюу гуравдагч этгээдэд олгохыг хориглоно. Баримт бичгийг хүлээж авсан этгээд “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн зөвшөөрөлгүйгээр тус баримт бичигт агуулагдсан аливаа мэдээллийг ямар ч тохиолдолд хуулбарлах буюу аливаа этгээдэд задруулж үл болно.

Энэхүү баримт бичиг нь Монгол улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Гаалийн ерөнхий газар болон Үндэсний статистикийн газар зэрэг байгууллагуудаас олгосон мэдээллийн эх сурвалж болон баримт бичигт дурдсан уул уурхайн хэд хэдэн компанийн удирдлагаас олгосон мэдээлэлд ихээхэн хэмжээгээр тулгуурласан болно. Эдгээр компаниудаас олгосон аливаа мэдээллийг бие даан нягтлаагүй бөгөөд мэдээлэл олгосон этгээдийн үзсэнээр мэдээлэл, тоо, баримт нь үнэн зөв бөгөөд бодитой гэж үзсэн болно. Энэхүү баримт бичигт агуулагдсан мэдээллийн үнэн зөв болон бүрэн байдалд ямар нэгэн хэлбэрээр шууд болон шууд бус баталгаа гаргахгүй бөгөөд баримт бичигт тусгагдсан мэдээлэл дээр тулгуурласан алдаа дутагдал, эсхүл баримт бичгийг хүлээн авсан этгээд мэдээллийг ашигласантай холбоотой аливаа нэгэн асуудал дээр энэхүү баримтын зохиогч нь ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

ТАЛАРХАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол улсад өрнөж буй эдийн засгийн хамгийн ач холбогдол бүхий томоохон үйл явдал бол Монгол улсын уул уурхайн салбарт өрнөж буй эдийн засгийн огцом хөгжил яах аргагүй мөн юм. Монгол улсын уул уурхайн салбарын эрчимтэй хөгжил нь нэг талаас дэлхийн хэмжээнд эрчим хүч болон эрдэс баялгийн нөөц шавхагдаж буй явдал, нөгөө талаас тэдгээрийн эрэлт хэрэгцээ эрчимтэй өсөж буйгаас улбаатай дэлхий эдийн засгийн томоохон тулгамдсан асуудлаас шалтгаалан эрдэс баялгийн үнэ дэлхийн зах зээл дээр огцом өсөж буйтай холбоотой болно.

Энэ үйл явдлын хамгийн чухал асуудал нь уг үйл явдал дээр дөрөөлөх замаар Монгол улс нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавх бүхий хувийн бизнесээс бүрдсэн эрүүл уур уурхайн салбарыг хөгжүүлэх, улмаар нийт эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

Монгол улсын уул уурхайн салбар болон ерөнхий эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой асуудлын нэг болох Монгол улсад өнгөт металл болон хар төмөрлөгийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бололцоо гэсэн чухал сэдвийг судлах боломж олдсон нь миний хувьд томоохон завшаан байлаа. Энэхүү судалгааг Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс (ГТХАН) хэрэгжүүлж буй “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.

Үйлдвэр, худалдааны яамны Нэгдсэн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга Д.Зоригтод мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн явдалд гүн талархал илэрхийлж байна. Үүнээс гадна, Төрийн өмчийн хорооны Хуулийн газрын дарга Гансүхэд энэхүү судалгаанд ашигласан мэдээлэл, тоо баримтыг цуглуулахад туслалцаа үзүүлсэн явдалд нь талархлаа илэрхийлэхийг хүсэж байна. Мөн түүнчлэн тоо баримт цуглуулахад ихээхэн туслалцаа үзүүлсэн Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газрын дарга Нанзаддорж, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Уул уурхайн газрын дарга Магванжав, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын шинжээч Соёмбобаатар, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн хуулийн хэлтсийн дарга Идэш болон Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын туслах Мядагмаа нарт талархаж байгаагаа илэрхийлье.

Ярилцлага авахыг зөвшөөрч өөрсдийнхөө санал бодол, шүүмжлэлээ илэрхийлж байсан уул уурхайн салбарын бизнес эрхлэгчдийн хувь нэмрийг өндрөөр үнэлж байгаагаа энэ дашрамд мэдэгдэж байна.

ОРШИЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсад өнгөт металл болон хар төмөрлөгийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бололцоог судлахад оршино. Судалгаагаар нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тулгарч буй саад тотгоруудыг олж тогтоохыг эрмэлзэв. Энэхүү судалгаа нь таван бүлгээс бүрдэж байгаа бөгөөд бүлэг тус бүр нь Монголын уул уурхайн салбарын ойрын ирээдүйн хөгжил болон Монгол улсын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлтэй холбоотой бие даасан асуудлуудыг тусгав.

Энэхүү судалгааг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр Үйлдвэр, худалдааны яамтай хамтран хэрэгжүүлж буй Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол-Германы хамтын ажиллагааны “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн хүрээнд олгосон судалгааны даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Судалгаанд хамрагдсан асуудлууд

Нэгдүгээрт бүлэгт Монгол улсын уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй төр засгийн өнөөгийн бодлогыг тусгав. Бодлогын болон зохицуулах байгууллагуудын гол сул талуудыг товч дурдахын зэрэгцээ Монгол улсын уул уурхайн салбарын ирээдүйн талаар товч тайлбарыг тусгасан болно.

Хоёрдугаар бүлэг нь Монголын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрлэлийн салбарын эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийн талаар өгүүлнэ. Салбар тус бүрийн талаарх дэлгэрэнгүй тайлбарын зэрэгцээ энэ бүлэгт салбарын гүйцэтгэлийн сүүлийн үеийн тоо баримтыг агуулахын зэрэгцээ салбарын ирээдүйн цаашдын хөгжилд нөлөөлөх бүтцийн өөрчлөлт болон энгийн нүдэнд анзаарагдахгүй зарим нэг баримтуудыг тусгасан болно.

Дараагийн бүлэг нь улс орны өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрийн салбарын гол байгууллагуудын талаар өгүүлнэ. Судалгааны энэ хэсэгт өнөөгийн нөхцөл байдлын үндсэн дээр эдгээр байгууллагуудын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн боловсруулах бололцоонд тулгарч буй бэрхшээл саад тотгоруудын талаар тусгасан болно.

Сүүлийн хоёр бүлэг нь ойрын ирээдүйд ашиглалтад орох магадлал өндөр бүхий томоохон ордуудын талаарх товч мэдээллийг агуулахын зэрэгцээ гадаадын зах зээл дэх хар төмөр болон өнгөт металлын эрэлт хэрэгцээний талаарх үнэлгээг өнгөцхөн агуулсан болно. Энэхүү хоёр хэсэг нь дэлгэрэнгүй дүн шинжилгээг хийхийг эрмэлзээгүй, харин Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд зарчмын нөлөө үзүүлэх гол хүчин зүйлс болон эдгээр салбарт явагдаж буй үйл явцыг ойлгоход шаардлагатай ерөнхий мэдээллийг агуулав.

Судалгааны аргачлал

Энэхүү баримт бичгийг боловсруулах явцад бид өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрлэлийн талаар ихээхэн хэмжээний мэдээлэл, тоо баримтыг цуглуулсан. Гэвч албан ёсны статистикийн олон тоо баримтууд нь холбогдох аж ахуйн байгууллагуудын гүйцэтгэлийн талаарх тоо баримттай нийцэхгүй байсан тул эдгээр тоо баримтад тулгуурлан Монголын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрлэлийн иж бүрэн дүр зургийг бий болгоход шаардлагад нийцэхгүй байсныг үүгээр мэдэгдэх нь зүйтэй болов уу.

Үүний зэрэгцээ тухайн аж ахуйн байгууллагуудын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үлдэгдэл нөөцийн хэмжээ, ашиглалтад орох магадлал өндөртэй ордуудын талаарх тоо баримт ба холбогдох мэдээлэл олдохгүй, олдсон зарим мэдээлэл нь үнэн зөв бус, тэдгээрийг бүрдүүлэх аргачлал нь эргэлзээтэй, бүртгэлийн тоо баримт нь алдаа, мадагтай байх нь нэгэн адил тулгарсан асуудал болсон юм.

Энэхүү баримт бичгийг боловсруулах зорилгоор тоо баримтыг дараах гол дөрвөн эх сурвалжийг ашигласан болно. Үүнд: Үндэсний статистикийн газар, Монгол улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ), Гаалийн ерөнхий газар болон Төрийн өмчийн хорооноос олгосон мэдээллээс авсан.

Монгол улсын уул уурхайн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогын үнэлгээг хийхдээ төрийн бодлого хэрэгжүүлэх явцад уул уурхайн салбар нь бизнес эрхлэгчдийн өнөөгийн эрэлт хэрэгцээнд хэрхэн нийцэж байгааг олж тогтоох замаар хийж гүйцэтгэсэн болно.

ХУРААНГҮЙ

Энэхүү баримт бичгийг Монгол улсын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрийн салбарын нэмэгдсэн өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц, бололцооны өнөөгийн байдлыг харуулах зорилгоор боловсруулсан болно.

Уг судалгаа нь юуны өмнө Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг олж тогтоох, хоёрдугаарт хар төмөр болон өнгөт металлын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тулгарч буй үндсэн саад бэрхшээлүүд болон эдгээр салбаруудын өнөөгийн байдал хэрхэн байгааг тусган харуулахыг эрмэлзэв. Иймээс энэ баримт бичиг нь дараах зорилгыг агуулсан болно. Үүнд: (1) хар төмөр болон өнгөт металлын салбарын талаар, мөн түүнчлэн эдгээр салбарын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой гол үйлдвэрүүд, тэдгээрийн нөөц бололцооны талаар тайлбарлах, (2) үйлдвэр, аж ахуйн байгууллагуудын удирдлагуудтай хийсэн ярилцлагын үндсэн дээр Монгол улсын хар төмөр болон өнгөт металлын салбарын өнөөгийн байдалд өгөх үнэлгээ, (3) Засгийн газрын гол бодлогын баримт бичгүүдтэй танилцсаны үндсэн дээр өнөөгийн бизнесийн орчинд өгөх үнэлгээ, мөн Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд нөлөөлөхүйц гол хүчин зүйлсийг олж тогтоох зорилгоор гадаадын барааны зах зээлийн хөгжлийн хандлагад дүн шинжилгээ зэргийг хийсэн болно.

Монгол улсын уул уурхай салбар нь өнгөрсөн хугацаанд хамгийн эрчимтэй хөгжиж ирсэн салбарын нэг юм. Монгол улсын уул уурхайг хөгжүүлэх чиглэлийн Засгийн газрын эдийн засгийн үндсэн зорилго нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн шинэ барилга, байгууламжийг байгуулж улс орны эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх гэсэн эдийн засгийн зорилтыг мөрдөж ирсэн болно. Хэдийгээр тодорхойлсон зорилт нь дээрх байдлаар байсан боловч бодит хэрэгжүүлэлт нь тунхаглан зарлаж байгаа зорилтуудаасаа ихээхэн зөрүүтэй байсан. Уул уурхайн салбарын бизнес эрхлэгчидтэй хийсэн ярилцлагаас үзэхэд төр засгийн бүх шатны үйл ажиллагаа нь ихээхэн дутагдалтай бөгөөд энэ талаар хурц шүүмжлэлүүд олноор гарч байлаа.

Зэсийн үйлдвэрлэл нь Монголын уул уурхайн салбарын үндсэн үйлдвэрлэлийн нэг бөгөөд уг салбар нь хоёр үйлдвэрээс бүрддэг. Монголын зэсийн экспорт нь хоёр бүтээгдэхүүнээс бүрддэг бөгөөд эдгээр нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэж буй зэсийн баяжмал болон Эрдмин компанийн үйлдвэрлэж буй катодын зэс юм. Монгол улсын зэсийн үйлдвэрлэл нь экспортын баримжаатай салбарын хувьд дэлхийн барааны зах зээлийн хөгжлийн чиг хандлагаас ихээхэн хэмжээгээр хамааралтай байж ирсэн. Өнөөгийн байдлаар Монгол улсад үйлдвэрлэсэн нийт зэсийн 80 хувийг Хятад руу экспортолж байна.

Хэдийгээр Монгол улс нь төмрийн хүдрээр харьцангуй баян боловч хар төмрийн салбар нь Монгол улсын хамгийн бага хөгжиж ирсэн салбарын нэг юм. Салбарыг хөгжүүлэхэд саад болж байсан үндсэн шалтгаанууд нь дэд бүтэц болон зохистой хөрөнгө оруулалт хомс байсантай холбоотой юм. Өнөөгийн байдлаар Монгол улсын хар төмрийн салбарыг үндсэндээ ганцхан үйлдвэр төлөөлж байгаа бол тэр нь Дарханы хар төмрийн үйлдвэр юм.

Алт олборлолт нь Монгол улсад хамгийн эрчимтэй хөгжиж буй салбарын нэг юм. Энэ салбарын өсөлтийг өдөөсөн гол шалтгаанууд нь ашигтай альтернатив үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх бололцооны хомс байдал, нөхөн сэргээлтийн зардал гаргадаггүйн улмаас үйлдвэрлэлийн зардал бага, дэлхийн зах зээл дэх үнийн таатай орчин, хайгуулын ажил сайтар хийж гүйцэтгэсэн орд худалдан авах үнэ хямд зэрэгтэй холбоотой байсан

болно. Өнөөгийн байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 123 алтны уурхай идэвхтэй үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа нь албан ёсоор эдгээрийн 117 нь шороон орд, үлдэж буй 6 нь үндсэн орд юм. Монгол улсын алтны салбарт явагдаж буй гол бүтцийн өөрчлөлт бол шороон орд шавхагдаж буй явдалтай холбоотой болно.

Алт нь (бэлэн мөнгөтэй адил) өвөрмөц шинж чанартай тул алтыг үндэслэн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь оновчтой бус буюу эдийн засгийн хувьд ач холбогдолгүй юм. Харин алтны нөөц харьцангуй их хэмжээгээр хуримтлуулах нь идэвхтэй дагалдах зах зээлийг хөгжүүлэх бололцоог бүрдүүлэхэд хүргэдэг. Дагалдах зах зээлийг шинэ уурхай ашиглалтад оруулахад шаардлагатай байгаа төслийн санхүүжилтийн эх үүсвэрээр бүрдүүлэх тогтолцооны хэлбэрээр ашиглаж болох юм.

Монгол улсын гянт болдын үйлдвэрлэл нь маш бага юм. Өнгөрсөн арван жилийн хугацаанд хятадын гянт болд үйлдвэрлэгчид нь дэлхийн зах зээл дээр хэт их давамгайлсан байдлаар ноёрхож ирсэн тул ихэнх хятадын бус гянт болд үйлдвэрлэгчид энэ хугацаанд дампуурсан билээ. Энэ хувь тавилан Монголын гянт болд үйлдвэрлэгчдийг нэгэн адил тойрон гараагүй юм. Урьд өмнө нь байсан цөөн тооны гянт болдын уурхайнууд нь хаагдсан бол зөвхөн саяхнаас гянт болдын үнэ бага зэрэг нэмэгдэх хандлагатай болсноор зарим нэгэн уурхай дахин ашиглалтад орж эхэлж байна. Монголын гянт болдын салбарын ирээдүйн хөгжил нь ихээхэн хэмжээгээр хятадын гянт болдын зах зээлийн хөгжлийн чиг хандлагаас хамаарах болно.

Хятад улсын эдийн засгийн асар хурдацтай өсөлт нь Монгол улсын уул уурхайн ойрын ирээдүйн хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн хэвээр байх нь тодорхой. Монгол улсын уул уурхайн салбарын хөгжил ялангуяа нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад “хятадын хүчин зүйлсийн” гүйцэтгэх үүрэг нь Монгол улсын Засгийн газрын ямар ч бодлогоос илүү нөлөөтэй байхаар байгаа юм. Хятадын өнгөт металлын талаарх асар их эрэлт хэрэгцээ нь Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй байх бөгөөд цаашид ч уул уурхайн салбарын хөгжилд томоохон түлхэц өгсөөр байх нь тодорхой юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО БОЛОН МОНГОЛ УЛСЫН ӨНГӨТ МЕТАЛЛ БОЛОН ХАР ТӨМӨРЛӨГИЙН САЛБАРЫН ИРЭЭДҮЙ

Уул уурхайн салбар нь Монгол улсад хамгийн эрчимтэй хөгжиж буй эдийн засгийн салбарын нэг юм. Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд эерэгээр нөлөөлж ирсэн гол хүчин зүйлс нь дэлхийн зах зээл дэх барааны үнийн өсөлт байсан бөгөөд үүний үр дагаварт олон улсын уул уурхайн компаниуд Монгол улс шиг шинээр бий болж буй зах зээлийн нөөц бололцоог судлах, эдгээр зах зээл дээрх урьд өмнө ашиглагдаж байгаагүй хоёрдогч түүхий эдийн нөөцийг ашиглах болсонтой холбоотой юм. Иймээс гадаадын шууд хөрөнгө оруулалт, “аз турших” (venture capital) хөрөнгө Монгол улсад их хэмжээгээр орж ирэх болсон тул энэ нь өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд Монгол улсын уул уурхайн салбарын хөгжилд томоохон түлхэц болсон. Өнгөрсөн таван жилийн хугацаанд Монгол улсын уул уурхайн салбарт урьд өмнө ажиглагдаж байгаагүй өсөлт гарсан. 2000 оны өсөлтийн үзүүлэлттэй харьцуулахад Монгол улсын эрдэс баялгийн салбар нь 43.3 хувиар өсжээ. 2004 онд Монгол улсыг хайгуулын үйл ажиллагаанд хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн эхний 10 дахь улс хэмээн тодорхойлсон буюу дэлхийн хэмжээнд хайгуулын ажилд нийт зарцуулсан хөрөнгийн 4 хувь нь Монгол улсад ногдож байжээ.

Өнөөгийн байдлаар Монгол улсын уул уурхайн салбар нь нийт төсвийн орлогын 18.3 хувийг бүрдүүлж байна. 2004 онд уул уурхайн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувь, харин нийт экспортын 60 орчим хувийг бүрдүүлж байсан болно.

1.1 Төрийн өнөөгийн бодлого

Уул уурхайн салбарын хөгжлийн үндсэн зорилтуудыг тодорхойлж буй тулгуур бодлогын баримт бичиг нь 2002 онд баталсан Монгол улсын Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл болно. Энэхүү баримт нь эрдэс баялгийн салбарын хөгжлийг тэргүүлэх ач холбогдол бүхий салбар хэмээн тодорхойлж, Монгол улсын уул уурхайн салбарын хөгжлийн 2010 он хүртэлх зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Өнөөгийн ашиглалтын болон хайгуулын лиценз олгох системийг сайжруулах,
2. Төрийн санхүүжилт бүхий хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх,
3. Геологийн хайгуулд гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудлыг хөхиүлэн дэмжих,
4. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарын түүхий эдийг боловсруулах түвшинг нэмэгдүүлэх улмаар цэвэр металл боловсруулах замаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр экспортыг нэмэгдүүлэх,
5. Газрын тосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
6. Таван толгой, Цагаан суварга болон Асгатын ордуудыг ашиглалтад оруулах,
7. Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчинг цаашид сайжруулах.

Онолын хувьд өнгөрсөн таван жилийн хугацаанд Монгол улсын Засгийн газар нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн шинэ барилга, байгууламжийг байгуулж улс орны эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх гэсэн эдийн засгийн зорилтыг мөрдөж ирсэн болно. Хэдийгээр тодорхойлсон зорилт дээрх байдлаар байсан боловч бодит хэрэгжилт нь цаасан дээр бичсэн байдлаасаа ихээхэн зөрүүтэй байсан байна.

Уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн үзэж буйгаар төслийн санхүүжилтийн зориулалтаар ашиглах хямд төсөр хөрөнгийн хомсдол, төрөл бүрийн саад тотгор учруулсан орон нутгийн төр засаг болон олон тооны төрийн байгууллагуудын дарамт зэрэг нь уул уурхайн салбарын хөгжлийг ихээхэн хэмжээгээр саармагжуулж байна гэжээ.

1.2 Хэрэгжилт, явцын бодит байдал

Уул уурхайн салбарын бизнес эрхлэгчтэй хийсэн ярилцлага нь төрийн өндөр албан тушаалтнуудын тайлбарлаж байгаа болон төрийн бодлогын тулгуур баримт бичгээс авах ойлголтоос ихээхэн зөрүүтэй дүр зургийг бий болгож байсан. Ихэнх бизнес эрхлэгчид нь төвийн болон орон нутгийн төр засгийн байгууллагын үйл ажиллагааны талаар ихээхэн сэтгэл дундуур байдаг юм байна. Тэдгээрийн үзэж буйгаар Засгийн газрын зорилтууд нь үндсэндээ олон нийтийн сурталчилгааны зориулалтаар овжин ашиглах зориулалт бүхий хий хоосон лоозон юм. Уул уурхайн салбарын дийлэнх бизнес эрхлэгчдийн үзэж буйгаар "уул уурхайн салбарт ямар нэгэн буруу зөрүү зүйл хийж байдлыг улам хүндрүүлэхгүй байцгаая" гэж байгаа бол төрийн бодлогоос үл хамааран объектив шалтгааны улмаас явагдаж буй үйл явдлаас төр нь аль болох оролцохгүйгээр холхон байх нь өнөөгийн төрийн хийж чадах хамгийн оновчтой зүйл юм"[1].

1.3 Идэвхгүй төр

Хэдийгээр дээр дурдсанаар төрийн бодлого нь "орд газруудыг уурхай болгож ашиглалтад оруулна" гэсэн зорилт дэвшүүлж байгаа боловч уул уурхайн салбарын бизнес эрхлэгчдийн дийлэнх нь дээрх бодлогын хэрэгжилтийн талаар ихээхэн сэтгэл дундуур байдаг бөгөөд бодит байдал дээр төр нь идэвхтэй бус байдаг хэмээн үздэг байна. Засгийн газрын баталсан үндсэн чиглэлд дурдсанчлан баяжуулах үйлдвэр байгуулах буюу уурхайг ашиглалтад оруулахад ямар нэгэн бодитой туслалцаа, дэмжлэгийг төрийн зүгээс огт үзүүлдэггүй. Өнөөгийн байдлаар ашиглалтад оруулаад байгаа бүх уурхайнууд нэг бол хувийн хөрөнгө оруулалт буюу аль эсвэл гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн дээр ашиглалтад орсон байна. Саяхан ашиглалтад ороод байгаа жилдээ 1,800.0 тонн молибден үйлдвэрлэх Эрдэнэтийн молибден болон жилдээ 65,000.0 тонн цайрын баяжмал үйлдвэрлэх Сүхбаатарын цайрын хоёр үйлдвэрүүд ч нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн дээр байгуулагдсан юм.

Хямд төсөр хөрөнгө оруулалт байхгүй байгаа нь уул уурхайн салбарын хөгжилд ихээхэн сөргөөр нөлөөлж ирсэн. Шинээр уурхай байгуулахад бизнес эрхлэгчдэд хамгийн ихээр хэрэгцээтэй байгаа төслийн хөрөнгө оруулалтыг өнөөгийн байдлаар нэг ч арилжааны банк санхүүжүүлдэггүй хэвээр байгаа. Гэтэл нөгөө талаас төрийн зүгээс шинэ уурхай байгуулахад шаардагдаж буй хөрөнгийн их үүсвэрийг бүрдүүлэх хямд төсөр санхүүгийн нөөцийг бүрдүүлэх талаар нэг ч алхам өнөөг хүртэл хийгээгүй хэвээр байгаа билээ.

1.4 "Түрүүлж ирснийг түрүүлж үйлчлэх" хэмээх зарчим

Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй Засгийн газрын бодлогын талаар дараах багц шүүмжлэл нь үндсэндээ эрх зүйн ба зохицуулалтын орчинтой холбоотой юм. Хайгуул болон олборлолт эрхэлж буй компаниудын сэтгэл хангалуун бус байгаа нь хайгуул буюу олборлолт эрхлэн явуулах гэж буй хуулийн этгээд болон хувь хүмүүст холбогдох лицензийг олгох журмыг тодорхойлж буй Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн заалттай холбоотой юм. Энэхүү зарчмын дагуу анх өргөдөл

[1] "Discover Mongolia 2005" Олон улсын уул уурхайн бага хурлын материал

өгсөн аливаа этгээд нь тухайн өргөдөл өгсөн талбайд хайгуулын буюу олборлолтын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болдог. Энэ заалт нь хайгуул сайтар хийгдсэн бусдын талбайг завшиж олборлолтын компаниудад борлуулах зорилгоор Кадастрын албаны дэргэд лицензийн наймаа эрхэлсэн хүмүүс олноор эргэлдэхэд хүргэсэн.

Уул уурхайн салбарт бизнес эрхэлж буй хүмүүсийн ихэнх нь уул уурхайн кадастрын албаны хээл хахуулийн талаар ихээхэн санаа зовж байгаагаа илэрхийлж байсан. Хэдийгээр шууд нотлох баримт байхгүй боловч бизнес эрхлэгчдийн дийлэнх нь Агентлаг дахь мэдээллийг тухайн агентлагийн албан хаагчид зүй бусаар ашигладаг гэдэгт ихээхэн итгэлтэй байна.

2002 онд Селигдар Монголиа компани нь ихээхэн хэмжээний хайгуулын ажил хийгдсэн өөрийн нэгэн талбайг лицензийн наймаа эрхэлдэг нэгэн этгээдэд алдсан түүхтэй. Үүний үр дүнд тухайн талбайг эргүүлэн авах зорилгоор дээрх компани нь хэд хэдэн арван мянган ам доллар төлсөн гэдэг. Ярилцлага өгч байсан хүмүүсийн үзэж байгаагаар ийм явдал нь зөвхөн агентлагийн дотроос нь хайгуул хийгдсэн талбайн талаар нарийвчилсан мэдээлэл олгосон тохиолдолд гарах боломжтой гэсэн байна. Иймэрхүү үйл явдлууд өнгөрсөн хугацаанд цөөнгүй гарч байсан бөгөөд хамгийн сүүлийн тохиолдол нь Монголын томоохон алт олборлогч компаниудын нэг болох Монгол газар компанитай тохиолдсон болно. Өнгөрсөн хугацаанд тус компани нь өөрийн хоёр талбайг лицензийн арилжаалагчдад алдсан бөгөөд эдгээр талбайнуудыг нь бусдад худалдсан байсан.

Бодитой хайгуул хийж байгаа хайгуулын буюу олборлолт эрхлэн явуулж буй ихэнх компаниудын үзэж буйгаар дээрх үзэгдэл нь компаниудын хөрөнгө болон бусад эх үүсвэрүүдийг үрэн таран хийж ихээхэн хэмжээний хохирол учруулснаар компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна гэжээ. Иймээс АМГТХЭГ-т ажиллаж буй төрийн албан хаагчдын хариуцлагыг чангатгаж тус байгууллагаас мэдээлэл задрах явдлыг таслан зогсоох зорилгоор АМГТХЭГ-ын үйл ажиллагааг сайжруулах шаардлага байгаа болно.

1.5 Орон нутгийн төр засаг

Орон нутгийн төр засгийн үйл ажиллагааны талаар ноцтой шүүмжлэл нэгэн адил гарч байсан. Лиценз эзэмшигчид нь ялангуяа бодитоор хайгуул хийж байгаа хэсэг нь өөрсдийн үйл ажиллагааны явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай харилцах шаардлага ихээхэн гардаг. Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг дэмжихийн оронд орон нутгийн төр засаг нь ихэнх тохиолдолд саад учруулдаг. Ямар нэгэн өөр зориулалтаар тухайн талбайг ашиглахааргүй байсан ч хиймлээр саад учруулах нь цөөнгүй тохиолдоно. Албан бус урамшуулал тухайн албан хаагчид олгоогүй тохиолдолд холбогдох зөвшөөрлийг орон нутгийн засаг захиргаанаас авах магадлал бага байдаг бололтой. Орон нутгийн засаг захиргаатай холбоотой энэ шүүмжлэл нь үндсэндээ хайгуулын болон ашиглалтын лиценз авсан тохиолдолд л орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөл авах шаардлагатай гэсэн Монгол улсын Ашигт малтмалын хуулийн заалттай холбоотой юм. Энэ байдал нь хуулийн заалтыг чөлөөтэй тайлбарлах үндэслэлийг бий болгосон болно. Албан бус урамшуулал олгоогүй нөхцөлд энэхүү заалтыг орон нутгийн засаг захиргаа нь гол төлөв өргөдөл өгөх явцыг удаашруулах буюу гацаах зорилгоор ашиглах явдал цөөнгүй байдаг бололтой.

Уул уурхайн компаниудын мэдэгдэж буйгаар дээрх байдал нь ялангуяа Сэлэнгэ болон Өмнөговь аймгуудад газар авсан болно. Энэ хоёр аймгийн орон нутгийн засаг захиргаа, цагдаа, шүүх, прокурор зэрэг гол төрийн байгууллагууд нь хээл хахуулийн харилцан холбоотой болсон байна хэмээн үздэг.

Хайгуулын компаниудын үзэж байгаагаар цаашид байдлыг улам даамжруулахгүй байх үүднээс орон нутгийн төр засгийн байгууллагуудыг шийдвэр гаргах явцаас ангижруулах шаардлагатай буюу уул уурхайн чиглэлийн тэдгээрийн эрх мэдлийг хорогдуулах нь зүйтэй болно. Энэ нь уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын хийж чадах тус дэмтэй цорын ганц зүйл юм.

Олборлолт эрхэлж буй байгууллагуудын сэтгэл дундуур байгаа нь нинжа буюу хууль бусаар алт олборлогчдын үйл ажиллагаатай нэгэн адил холбоотой юм. Орон нутгийн засаг захиргаанд таалагдаагүй буюу тэдгээртэй үл ойлголцсон аж ахуйн нэгжийн ашиглалтын талбайд нинжа нарыг идэвхтэй ажиллахыг шууд бус хэлбэрээр хөхиүлэн дэмжих явдал мэр сэр гарах болсон байна. Өнгөрсөн хугацаанд Алтан Дорнод Монгол компанийн ашиглалтын талбайд болж өнгөрсөн үйл явдал нь үүний нэг тод жишээ юм. Орон нутгийн төр засгийн байгууллагууд нь нинжа нарыг Алтан Дорнод Монгол компанийн ашиглалтын талбайд ажиллахад үндсэндээ хориглох бус харин гар хумхин сууж шууд бус хэлбэрээр дэмжсэн байна.

1.6 Уул уурхайн салбарын тулгамдсан асуудлууд

Нөхөн сэргээлт

Уул уурхайн компаниудаас өнөөгийн байдлаар хэрэгжүүлж буй нөхөн сэргээлтийн хэмжээ уул уурхай хөгжсөн улс орнуудад тогтоосон хэмжээнээс ихээхэн доогуур байна. Ихэнх компани нөхөн сэргээлтийг үндсэндээ нэр төдий хийж байна. Жижиг компаниуд өөрсдийн ашигласан “уурхайг” зүгээр л орхиод явах нь элбэг тохиолддог. Ашиглаж буй ордын орчин тойронд дахь гол, мөрний эвдрэл, байгаль орчны бохирдол, газар нутгийн талхигдал, хөрсний эвдрэл, ойн сүйтгэл зэрэг нь аюултай хэмжээнд хүрээд байна. Хаагдсан уурхайд хууль бусаар алт олборлогчид ажиллаж эхлэхэд байдал улам ноцтой болдог. Зохицуулагч байгууллагаас нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийхийг уул уурхайн компаниудаас шаардвал ихэнх жижиг уурхайнууд хаагдахад хүрнэ. Ийм байдал нь ялангуяа алтны компаниудын хувьд хамаатай юм.

Тухайлбал, одоогоор, нөөц муутай орд ашиглаж жилдээ 0.5-5 кг алт олборлодог жижиг компани олон байна. Иймэрхүү ордыг арилжааны зориулалтаар томоохон алт олборлогчид хэзээ ч ашигладаггүй юм. 2004 оны эцсийн байдлаар жилдээ 5 кг-аас бага алт олборлосон компани 24 байсан бол 71 компани жилдээ 30 кг-аас бага алт олборлож байжээ. Өөрөөр хэлбэл, нийт алтны компаниудын гуравны хоёрын олборлосон алтны хэмжээ нь эдийн засгийн ач холбогдлын хувьд өчүүхэн юм. Гэтэл тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнд гарч байгаа нийгэм, байгаль орчны сөрөг нөлөө нь маш их бөгөөд зарим тохиолдолд тэдгээрийн сөрөг нөлөө нь ихээхэн хортой ч байх жишээтэй. Судалгаанаас үзэхэд, эдгээр компаниуд нөхөн сэргээлтийн ажлын зардал гаргахгүй байсан тулдаа л өдий болтол оршин тогтносоор иржээ.

Уул уурхайн компаниудад тавигдах нөхөн сэргээлтийн ажлын шаардлагыг чангатгавал юуны өмнө дээр дурдсан жижиг уул уурхайн компаниуд хаагдахад хүрнэ. Ийм арга хэмжээ нь бүх талаар ихээхэн ашигтай зүйл болно. Мөн гол төлөв хаягдсан уурхайд хууль бусаар алт олборлодог алт олборлогчдын үйл ажиллагаа хумигдана.

Жижиг компаниудын ашиглаж буй ордын нөөц шавхагдах, эдгээр компаниуд цаашид хайгуулын ажил хийх чадваргүй, үйлдвэрлэлийн үр ашиг нь эргэлзээтэй байгаагаас хангалттай санхүүжилт олж авч чадахгүй байгаа зэрэг нь жижиг компаниудын тоо ойрын ирээдүйд ихээхэн цөөрөхөд хүргэнэ.

Хайгуулын ажил

Тус улсад хайгуулын ажил харьцангуй идэвхжиж байгаа боловч, шинээр олдож буй ордын нөөцийн хэмжээ нь улс орны уул уурхайн салбарын урт удаан хугацааны хөгжлийг хангахуйц хэмжээнд хүрэхээргүй хэвээр байна. Үүний хажуугаар, тус улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 15 хувьд нь л 1:50,000-ын нарийвчилсан зураглалыг хийсэн байгаа нь хайгуулын ажил хангалтгүй байгаагийн бас нэгэн тод нотолгоо юм.

Өнөөгийн байдлын хайгуулын талбайн газар зүйн зургийг дор харуулав. Зургаас үзэхэд хайгуул хэрхэн өргөн хүрээтэй хийгдэж байгаа нь харагдаж байгаа болов уу.

Зураг 1: Хайгуулын лицензийн байршлын зураг



Эх сурвалж: www.MRPAM.mn/map.html

Ер нь дэлхий нийтийн хэмжээнд геологийн хайгуулын ажлыг хөрөнгийн зах зээлийн эх сурвалжаас санхүүжүүлдэг бол Монголын нөхцөлд уул уурхайн компаниуд нь шаардлагатай хайгуулын ажлаа өөрсдийн эх үүсвэрээр гүйцэтгэж ирсэн.

Өнөөгийн байдлаар Монгол улсад уул уурхайн компаниудад хайгуулын ажил хийж гүйцэтгэхэд тус дэм болох нэг ч санхүүгийн байгууллага байхгүй хэвээр байгаа юм. Энэхүү судалгааг хийх явцад Монгол банк дахь алтны нөөцийг нэмэгдүүлэх, улмаар үнэт металлын биржийг байгуулах замаар Монгол улсад хайгуулын ажлыг нэмэгдүүлэхэд төр засгийн гүйцэтгэх үүрэг илүү их байж болох байгаа нь тогтоогдсон болно.

Өнгөрсөн хугацаанд тус улсад хайгуулын ажлыг өргөжүүлэх, шинэ уурхайг ашиглалтад оруулах зэрэгт тулгарч байсан гол саад бэрхшээл нь банкны зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино байгаатай холбоотой байсан. Үүний нэгэн нотолгоо бол сүүлийн үед хайгуулын ажил өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн, нөөц сайтай, ирээдүйтэй хэд хэдэн алтны ордыг эзэмших эрхийг шилжүүлсэн явдал юм. Энэ нь ердөө л хуучин эзэмшигчид нь уурхайг ажиллуулахад шаардлагатай хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийг олж авч чадаагүйтэй холбоотой. Ордын эзэмших эрхийг шилжүүлэх хамгийн тод жишээ нь Монгол улсын хамгийн том үндсэн орд болох Бороогийн алтны орд байсан болно.

1.7 Хэтийн төлөв

Хэдийгээр Монгол улсын уул уурхайн огцом хөгжлийг төрийн өндөр албан тушаалтнууд ихэвчлэн Ашигт малтмалын тухай хууль 1997 онд батлагдсанаар эрх зүйн таатай орчинг амжилттай бүрдүүлсэнтэй холбон тайлбарлах дуртай байдаг боловч бодит байдал дээр дэлхийн зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж Монгол улсын хувьд эерэг нөхцөл бүрдсэнтэй холбоотой юм. Иймээс Монгол улсын уул уурхайн салбарын цаашдын хөгжил нь дэлхийн зах зээлийн хэтийн хөгжлийн төлөв байдлаас ихээхэн хамааралтай байх болно. Харин дэлхийн зах зээлийн ирээдүйн хөгжлийг тодорхойлж буй томоохон хүчин зүйлсийн нэг бол хятадын хүчин зүйлс юм.

Хятад улсын эрдэс, түүхий эдийн эрэлт хэрэгцээ, ялангуяа зэс болон эрчим хүчний талаарх эрэлт хэрэгцээ нь ойрын ирээдүйд тогтвортой өссөн хэвээр байх тул үүний үр дүнд Монгол улсын уул уурхайн салбар цаашид дунд хугацаанд тогтвортой хөгжих хандлагатай байгаа юм. Монгол улс нь өнөөгийн байдлаар дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засаг болох Хятад улсын эдийн засгийн хувьд хөгжлийн хамгийн чухал үе шатанд хүрээд байгаа юм. Ойрын ирээдүйд Хятад улс нь Монгол улсын эдийн засагт хамгийн чухал нөлөөг үзүүлэхээр байгаа. Иймээс Хятад улсын эрдэс баялгийн талаарх асар их эрэлт хэрэгцээ нь Монгол улсын уул уурхайн салбарт хүчтэй нөлөөлөх болно.

Хүснэгт 1: Монгол улсын уул уурхайн салбарын хөгжлийн хандлага

	2004	2005	2006	2007
Зэсийн баяжмал, 000’ тн	514.1	500.7	490.4	-
Молибдены баяжмал, тн	1,140	2,431.1	-	-
Молибдены, тн	-	400.0	1,500.0	1,800
Рений, тн	-	0.2	1.0	1.0
Катодын зэс, тн	2,451.1	2,700	3,100	3,500
Алт, тн	18.06	21.6	22.1	
Төмрийн хүдэр, 000’ тн	31.0	132.6	-	-
Гянт болдын баяжмал, 000’ тн	49.5	65.0	-	-
Цайрын баяжмал, тн	-	20.129	48.31	53.67

Эх сурвалж: Нийгэм эдийн засгийн хөгжлийн ерөнхий чиглэл 2006 болон 2008; АМГТХЭГ, Цайрт Минералс, Эрдмин компани, ЭУБҮ;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН ЭКСПОРТЫН БОЛОН ХУДАЛДААНЫ НИЙТ ХЭМЖЭЭНД ХАР БОЛОН ӨНГӨТ МЕТАЛЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

2.1 Зэсийн үйлдвэрлэлийн салбар

Үйлдвэрлэл

Өнгөрсөн хорин жилийн хугацаанд Монгол улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа зэсийн үйлдвэрлэл нь Монголын уул уурхайн салбарын үндсэн үйлдвэрлэлийн нэг мөн билээ. Хуучин Зөвлөлт холбоот улсын техникийн туслалцаатайгаар 70 оны эхээр байгуулагдсан Эрдэнэтийн уул уурхайн корпораци (ЭУУК) нь зэсийн үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэх байр суурь эзэлдэг. Өнөөгийн байдлаар Эрдэнэтийн уул уурхайн корпораци нь өөрийн үндсэн бүтээгдэхүүн болох зэс болон молибдены баяжмал үйлдвэрлэх зориулалтаар зэсийн хүдрийг олборлодог. 1997 оноос хойш зэсийн баяжмалын үйлдвэрлэл тасралтгүй өссөн байна. 2004 оны эцсийн байдлаар Эрдэнэт уурхай 514.1 мянган тонн зэсийн болон 2,333.9 тон молибдены баяжмалыг үйлдвэрлэсэн болно.

Хүснэгт 2: 1997-2004 онууд дахь зэсийн үйлдвэрлэл

Үйлдвэрлэл	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Зэсийн хүдэр, 000' метрик тонн	442.0	451.2	453.7	457.7	487.6	488.0	511.3	514.1
Зэсийн агуулга, метрик тонн	124,000	125,000	126,000	125,000	133,000	131,000	130,270	130,000
Молибдены баяжмал, метрик тонн	-	-	-	2,627.6	2,798.0	3,068.0	3,519.3	2,333.9
Молибдены агуулга, метрик тонн	2,202	1,993	1,953	1,336	1,423	1,590	1,793	1,140
Зэсийн катод, метрик тонн	2,709.4	2,310.2	1552.0	684.86	1,388.4	1,490.9	1,328.7	2,451.07

Эх сурвалж: АМГТХЭГ болон ГЕГ

Монголын улсын зэсийн үйлдвэрлэл нь экспортын салбарын хувьд дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлийн өөрчлөлтөд өртөмтгий байдаг. Өнгөрсөн хугацаанд зэсийн үнэ туйлын тогтворгүй байсан. 2001-2002 онуудын Хойд Америкийн болон Баруун Европын эдийн засгийн хямралаас гадна 90 оны сүүлээр Эскондидо, Серро, Колорадо, Залдивар ба Куэбрада Бланка зэрэг томоохон зэсийн уурхайгаас хямд өртгөөр олборлолт хийсний улмаас үүссэн зэсийн илүүдэл нөөц, хуримтлал зэрэг хүчин зүйлсүүд нь дэлхийн зах зээлийн зэсийн үнийн бууралтад гол нөлөө үзүүлжээ.

Хэдийгээр 2002 оны эхээр зэсийн нөөц илүүдэлтэй байсан ч Хойд Америкийн эдийн засаг нь хямралаас гарч, зэсийн хэрэгцээ өсөж, мөн Хятад улсын зэсийн хэрэгцээ огцом өсөж байгаагаас хамааралтай 2002 оны дундуур зэсийн үнэ тогтвортой байдлаар дахин нэмэгдэж эхэлсэн. 2004 оны сүүлээр өнгөрсөн хорин жилийн хугацаанд анх удаа зэсийн хэрэгцээ нөөцөө даван гарч тухайн үеийн зах зээлийн үнэ жилийн 20 хувиар өссөн байна.

Хятад улсын зэсийн хэрэгцээний өсөлтийн үндсэн шалтгаан нь хувийн аж үйлдвэрийн хурдацтай хөгжиж байгаатай холбоотой. Хятад улсын хэрэгцээ хурдацтай өссөний улмаас зэсийн үнэ ойрын ирээдүйд тогтвортой байна гэж зэсийн аж үйлдвэрлэлийн олон улсын хэмжээний судлаачид үзэж байна.

Зураг 2: Монгол улсын зэсийн үйлдвэрлэлийг Лондонгийн металлын биржийн зэсийн үнэтэй харьцуулсан байдал, 1997-2004 онууд



Эх сурвалж: Олон улсын Зэсийн Судалгааны Ажлын Хэсэг

Монгол улсын зэсийн үйлдвэрлэлийн экспортыг Эрдэнэт үйлдвэрийн олборлодог зэсийн хүдэр болон Эрдмин компанийн үйлдвэрлэдэг зэсийн катод зэрэг хоёр нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бүрдүүлдэг. Зэсийн үйлдвэрлэлийн салбар нь улс орны экспортын нийт орлогын дөрөвний нэгийг бүрдүүлдэг байна.

Хүснэгт 3: Монголын зэсийн экспорт, 2000-2004 онууд

	2000	2001	2002	2003	2004
Улсын нийт экспортын орлого, ам.доллараар	535.8	521.5	524.0	615.9	
Зэсийн нийт экспортын хэмжээ, ам.доллараар	161.5	149.96	142.46	165.95	286.75
Үүнээс:					
Зэсийн баяжмалын экспорт, ам.доллараар	160.3	147.9	140.2	163.7	284.3
Катодын зэсийн экспорт, Ам.доллараар	1.2	2.06	2.26	2.25	2.45
Улсын нийт экспорттой харьцуулсан нийт зэсийн экспортын хувь хэмжээ, %	30.1	28.7	27.2	26.9	

Эх сурвалж: МУСГ, ГЕГ, АМГТХЭГ болон АХБ-ны 2003 оны тайлан

Өнгөрсөн жилүүдэд Эрдэнэт нь ил уурхай олборлож байгаа хэмжээнээсээ илүү их хэмжээг экспортолжээ. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрүүдийн нэгэн адил Эрдэнэт үйлдвэр жил бүр тайлангийн хугацаанд олборлосон бүтээгдэхүүний тайлан, мэдээгээ АМГТХЕГ-т гаргаж өгдөг. Гэтэл Монголын Гаалийн Ерөнхий Газрын мэдээгээр экспортод гаргасан бүтээгдэхүүний хэмжээг олборлосон хэмжээнд харьцуулахад олборлосон хэмжээ нь тогтмол илүү байна. АМГТХЕГ-ийн статистикийн мэдээгээр

Эрдэнэтийн зэсийн үйлдвэр 2004 оны эцсийн байдлаар 514.1 мянган тонн зэсийн хүдэр олборлосон байхад тухайн жилдээ 562.6 мянган тонн бүтээгдэхүүн экспортод гаргасан байна. Энэхүү тоон хоёр үзүүлэлтийн зөрүү мэдэгдхүйц их тул өнгөрсөн жилүүдэд хуримталсан зэсийн хүдрээ Эрдэнэтийн уул уурхайн үйлдвэр экспортод гаргалаа гэж хэлэх боломжгүй бөгөөд үндэслэл муутай болоод байна. АМГТХЕГ болон ГЕГ-ын зөрүүтэй тоон үзүүлэлтүүдийн ялгааны талаар Эрдэнэт үйлдвэрийн удирдлага ч тодорхой тайлбар өгөх боломжгүй байсан тул эдгээр статистикийн үзүүлэлтүүдийн зөрүүг бодиттойгоор тайлбарлах боломжгүй байна.

Хүснэгт 4: Зэсийн экспортыг үйлдвэрлэлтэй харьцуулсан нь, 1997-2004 онууд

Бүтээгдэхүүн	2000	2001	2002	2003	2004
Экспортолсон зэсийн баяжмал, 000’ тн	495.99	540.89	548.59	569.9	562.64
Үйлдвэрлэсэн зэсийн баяжмал, 000’ тн	457.7	487.6	488.0	511.3	514.1
Дээрх хоёр үзүүлэлтийн зөрүү	38.29	53.29	60.59	58.6	48.54

Эх сурвалж: АМГТХЭГ болон ГЕГ

Иймд мэдээлэл гуйвуулах ямар нэгэн хүсэл эрмэлзэлгүй байгууллага болох ГЕГ-ийн статистикийн үзүүлэлт нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн экспортод гаргасан зэсийн хүдрийн бүтээгдэхүүний нийт хэмжээ нь үнэнд илүү нийцнэ гэж үзлээ.

Үйлдвэрлэгчид

Эрдэнэтийн уул уурхайн корпораци

Эрдэнэт Овоо гэж нэрлэгдэх зэс молибдены нэг ордыг түшиглэн байгуулагдсан, хоорондоо уялдаа холбоотой хоёрхон үйлдвэр Монголын зэсийн үйлдвэрлэлийн салбарыг төлөөлдөг.

1973 онд байгуулагдсан бүгд сайн мэдэх Монгол-Оросын хамтарсан Эрдэнэтийн уул уурхайн корпораци (эсхүл Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр гэх) нь салбартаа зонхилох томоохон үйлдвэр. Өнөөгийн байдлаар 0.47% зэс болон 0.013% молибдены агуулгатай 1.27 миллиард тонн хүдрийн (өөрөөр хэлбэл 5.5 сая тонн зэс болон 167 мянган тонн)[2] нөөцтэй гэж тогтоогдсон ил уурхай юм.

Эрдэнэтийн ил уурхайн олборлолт нь уламжлалт ил аргаар явагддаг ба хаягдал хөрсийг ордын захад нөөцөлнө. Ил уурхайн нь 2,500 м урт, 1,150 метр өргөн. Ил уурхайг уламжлалт ил аргаар олборлон ашиглаж байгаа тул ажиллуулах зарчим нь энгийн, үүнд өрөмдлөг болон дэлбэрэлт, хөрс хуулалт, гаргаж авах гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Ил уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл 1 км орчим зайд хүдэр тээвэрлэдэг байна. Гаргаж авсан хүдрийг баяжуулах фабрикт хөрвүүлэх зарчим дээр зэсийн болон молибдены баяжмалыг гаргаж авдаг байна. Тус Корпораци нь 2004 оны эцсийн байдлаар ойролцоогоор 514.1 мянган тонн 25.4%-тай зэсийн баяжмал, 2.33 мянган тонн 48.8%-тай молибдены баяжмалыг тус тус үйлдвэрлэжээ.
Эрдэнэт баяжуулах үйлдвэр нь томоохон ил уурхайн хувьд улс орны уул уурхайн салбарт чухал үүргийг гүйцэтгэдэг. 2004 оны байдлаар Корпораци нь улс орны экспортын 29 орчим хувийг эзэлж ДНБ-ний 23 гаруй хувийг бүрдүүлсэн байна.

[2] 2002 оны эцсийн байдлаар

Эрдмин Компани

Хоёр дахь үйлдвэр болох Монгол-Америкийн хамтарсан Эрдмин компани нь Эрдэнэтийн зэсийн хүдрийн ил уурхайн овоолгуудад гаргасан исэлдсэн ба балансын бус хүдрээс нуруулдан уусгах (SX-EW) технологиор катодын зэсийг үйлдвэрлэдэг гидро-металлурги төрлийн бага оврын үйлдвэр юм. Тус үйлдвэрийг 1995 онд 51 хувийг Эрдэнэт Концерн, 49 хувийг РСМ компани тус тус эзэмшихээр тохирон РСМ компани ба Эрдэнэт Концерн хоёр хамтран байгуулсан. Эрдмин компанийг байгуулах үндсэн зорилго нь Монголын нөхцөлд нуруулдан уусгах (SX-EW) технологийг ашиглах боломжтой эсэхийг туршихад оршиж байв. Үйлдвэрийн төслийн хүчин чадал жилд 3 мянган тонн катодын зэс гаргах байсан ч өнөөгийн байдлаар тус үйлдвэр нь ойролцоогоор 2,500 тонн катодын зэс үйлдвэрлэдэг. Эрдмин үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2005 онд зэс утас гаргах жижиг хэмжээний цехийг нэмж байгуулсан. Төслийн тооцоогоор зэс утас үйлдвэрлэх цех нь жилд 350-450 тонн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай юм. Нийт бүтээгдэхүүнийг Япон болон Өмнөд Солонгос улс руу гаргадаг байна.

2.2 Хар төмрийн үйлдвэрлэл

Үйлдвэрлэл

Монгол улс төмрийн ордоор баялаг улс орон. Нийт улс орны хэмжээнд 427.1 сая тонн[3] нөөцтэй гэсэн тооцоо байдаг байна. Хуучин социализмын үед хэд хэдэн нилээд их нөөцтэй байж болзошгүй ордуудыг нээж илрүүлсэн хэдий ч нэгийг нь ч ашиглаж хөгжүүлээгүй байна. Уурхай болгоныг хөгжүүлэхэд саад бэрхшээл болдог гол хүчин зүйлсүүд нь хөрөнгө оруулалтын хомсдол болон буурай дэд бүтцийн хөгжлөөс хамаардаг байна. Өнөөгийн байдлаар Төмөртэйн орд (Сэлэнгэ аймагт орших)[4], Төмөр Толгойн орд болон Баян голын орд гэх гурван ордыг сайн ашиглаж байгаа бөгөөд эдгээр нь өөр хоорондоо ойрхон байрласан бараг нэг аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог ордууд байна. 70, 80 онуудад эдгээр ордуудын хайгуул судалгааны ажлууд бүрэн хийгдэж ойролцоогоор 377.1 сая тонн төмрийн хүдрийн нөөцтэй гэж тогтоогджээ.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг байгуулах санаачилга нь Монгол улсын Засгийн газрын дээр дурдсан ордуудыг хөгжүүлэх зорилготой уялдаа холбоотой байсан. Гэвч хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, эрсдэл багасгах үүднээс авч үзвэл хаягдал төмөр хайлуулах нь бага оврын үйлдвэрийн хувьд Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс илүү өгөөжтэй болохыг урьдчилсан тооцоо, төсөл харуулжээ. Иймд хар металл боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах санаачилга нь Дархан хотод хаягдал төмөр хайлуулах үйлдвэр байгуулснаар дуусгавар болжээ.

Үйлдвэрлэгчид

Монголын хар төмөрлөгийн салбарыг бага оврын үйлдвэр болох Дарханы төмөрлөгийн үйлдвэр төлөөлнө. Дарханы төмөрлөгийн үйлдвэр өөр өөр хэмжээтэй гурван төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, үүнд ган бэлдэц, ган арматур ба булан болно. Хэрэв ган бэлдцийг экспортын чиглэлээр үйлдвэрлэдэг бол арматур болон буланг дотоодын хэрэглэгчдэд зориулан үйлдвэрлэдэг байна.

[3] 2006-2008 онуудад геологи, уул уурхайн салбарын талаарх ойрийн жилүүдэд баримтлах чиглэл
[4] Сэлэнгэ аймгийн Төмөртэйн төмрийн хүдрийн ордноос гадна ижил нэртэй цайрийн орд Сүхбаатар аймагт бий болохыг анхаарна уу

Хүснэгт 5: Төмөрлөг бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба экспорт, 2000-2004 онууд

	2000	2001	2002	2003	2004
Ган бэлдцийн үйлдвэрлэл, 000'тонн	13.0	10.0	15.9	39.11	54.51
Ган бэлдцийн экспорт, 000' тонн	5.6	7.8	2.6	5.8	3.9
Экспортод гаргасан бүтээгдэхүүн жин, %	43%	78%	16.4%	14.8%	7.1%

Эх сурвалж: МҮСГ

Хэдийгээр Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлж чадсан ч экспортын хэмжээ нэг түвшинд хэвээр үлдэж, харин дотоодын хэрэгцээнд үйлдвэрлэсэн хэмжээ өссөнөөр тэмдэглэгджээ.

Монголын хар төмрийн үйлдвэрлэлийн зургийг бүрэн гаргахын тулд Эрдэнэтийн төмрийн үйлдвэрийг дурьдах шаардлагатай. Эрдэнэт төмрийн үйлдвэр бол МИКО холдинг эзэмшлийн хувийн үйлдвэр билээ. Компанийг 90 оны дундуур Эрдэнэт баяжуулах үйлдвэрийн оролцоотойгоор байгуулсан. Эрдэнэт баяжуулах үйлдвэрийг төмрийн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор энэхүү бага оврын үйлдвэрийг байгуулжээ. Өнөө үед тус үйлдвэр нь Эрдэнэт баяжуулах үйлдвэрийн баяжуулах фабрикийн хүдэр тээрэмд зориулан үрлэн бөмбөлөг гаргадаг. Эдгээр үрлэн бөмбөлгийг гаргахын тулд Эрдэнэтийн төмрийн үйлдвэр нь Дарханы Төмөрлөгийн үйлдвэрээс бэлдэц авдаг байна. Эдийн засгийн үр өгөөжийг авч үзвэл эдгээр бөмбөлгүүдийг Дарханы төмөрлөгийн үйлдвэр гаргаж Эрдэнэт баяжуулах үйлдвэрт шууд нийлүүлэх нь логикийн хувьд энгийн бөгөөд ашигтай хэлбэр байх боловч тэр болгон амьдрал дээр нөхцөл байдал тийм хялбар энгийн биш байдаг байна. Энэхүү завсрын компани нь Эрдэнэт баяжуулах үйлдвэрт бөмбөлөг гарган нийлүүлэх зах зээл дээр хүчтэйгээр ноёрхсон бололтой.

Дээрх үйлдвэрүүдээс гадна бага оврын уурхай өөрийн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Энэ нь Дарханы төмөрлөгийн үйлдвэрт харьяалагдаж байсан Төмөртэйн төмрийн ордыг түшиглэн байгуулсан ил уурхай юм. Уурхай нь Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог бөгөөд уурхайг 2004 оноос эхлэн Монгол-Хятадын хамтарсан үйлдвэр болох БЛТ компани ашиглаж байна.

Хэдийгээр ордын нөөцийг дахин үнэлэх ажил хийгдээгүй ч компанийн удирдлага ордын хайгуул судалгааны ажлыг 2004 онд бүрэн гүйцэтгэсэн гэж мэдэгдэж байна. Тус компани нь төмрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага оврын үйлдвэр байгуулах бодолтой байгаа ч үйлдвэрийг барьж байгуулах хөрөнгө оруулалт дутагдаж байна. Өнөөгийн байдлаар тус компани үйлдвэр байгуулах нэмэлт хөрөнгө оруулалтыг идэвхтэй хайж байна. Тэр болтол олборлосон төмрийн хүдрийг Хятадын зах зээл рүү экспортод гаргадаг. Экспортод гаргах хэмжээ харьцангуй бага бөгөөд 2004 оны сүүлээр гэхэд 31.5 мянган тонн хүдэр олборлосон байна. Хятад улс руу тээвэрлэх ачааны вагон хүрэлцээгүйгээс тус уурхайн олборлолт ойрын ирээдүйд мэдэгдхүйц хэмжээгээр нэмэгдэх магадлал нь бага байна.

2.3 Алтны салбар

Үйлдвэрлэл

Аж үйлдвэрлэлийн зориулалтаар алт олборлох явдал нь Монгол улсад 60-аад оны сүүлээр идэвхтэй хөгжиж эхэлсэн боловч 1990-ээд оны дунд үеэс бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн түвшин хурдацтай нэмэгдэж ирсэн. 1990 оны эхээр улсын нийт алт олборлолтын хэмжээ жилд ойролцоогоор 0.65-0.7 тонн байлаа. Харин 90-ээд оны сүүл гэхэд алт олборлолтын хэмжээ жилд 10.0 тоннд хүрсэн байв. Үүнээс үзэхэд тус улсад нийт олборлосон алтны гуравны хоёрыг сүүлийн 6 жилийн дотор олборлосон байна.

Өнөөдөр алт олборлолт нь Монгол улсын эдийн засгийн бусад аль ч салбарыг бодвол хамгийн эрчимтэй хөгжиж буй салбарын нэг юм. Нөхөн сэргээлтийн ажлыг зохистой хэмжээнд хийж гүйцэтгэхийг хатуу шаардаагүй сул хууль, эрх зүйн орчноос үүдэж дийлэнх уул уурхайн компаниуд нь нөхөн сэргээлтийн ажлыг хийхгүй байснаар үйл ажиллагааны зардлаа буруулдаг явдал, хямд төсөр хөдөлмөрийн хүч, өндөр эрэлт хэрэгцээ болон нэгж бүтээгдэхүүний өндөр ашиг зэрэг шалтгаанаас Монголын алтны компаниуд дэлхийн зах зээлийн үнээс хавьгүй бага өртгөөр алт олборлох бололцоотой байна. Үйл ажиллагааны бага зардал, нэгж бүтээгдэхүүний өндөр ашиг болон өндөр эрэлт хэрэгцээ зэрэг хүчин зүйлс нь тус салбарын хөгжилд ихээхэн нөлөөлж ирсэн болно. Салбарын өсөлтөд дараах гол шалтгаанууд нөлөөлсөн байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд алт олборлолтын салбар ихээхэн хөгжсөн нь алтны ордын дийлэнх нь ашиглахад нарийн технологи шаарддаггүй шороон ордууд байсантай холбоотой.
- Нөөц нь мэдэгдсэн, ашиглахад бэлэн алтны шороон ордууд цөөнгүй байсан бөгөөд тэдгээрийн дийлэнхийг социализмын үед нээж бүрэн судалсан байсан. Иймээс үндсэндээ алт олборлогч компаниудын нэг нь ч эрэл хайгуулд их хэмжээний мөнгө зараагүй учраас тэд өдийг хүртэл зардлаа бага хэмжээнд барьж чадсан. Одоогоор ашиглаж буй ихэнх ордуудыг маш хямдхан худалдаж авч байсан бөгөөд зөвхөн саяхнаас эхлэн алт олборлогч компаниуд шинэ орд нээхээр зарим нэг эрэл хайгуулын ажлыг эхлээд байна.
- Альтернатив аж үйлдвэрийн хомс байдал. Томоохон хөрөнгө оруулалт, үнэтэй тоног төхөөрөмж, нарийн технологи шаарддаг, ажиллагаа ихтэй бусад эрдсийн баялгийг бодвол алтны үйлдвэрлэл нь өртөг багатай.
- Алтны компаниудын ихэнх нь үйл ажиллагааны зардал бага байдаг нь эдгээр компаниудын нэг нь ч ашигласан газраа зохих ёсоор нөхөн сэргээдэггүйгээр тайлбарлагдана. Нөхөн сэргээлтийн шаардлага чанд хатуу байсан бол нилээд олон алтны компанийн үйл ажиллагаа зогсон байж болзошгүй.
- Эцэст нь дэлхийн зах зээл дэх алтны үнийн өсөлтийн чиг хандлага таатай байсантай бас холбоотой болно.

Одоогоор ихэнх олборлож буй алт нь шороон ордоос гарган авсан болно. Улсын нийт алтны батлагдсан нөөц 127.0 тонн байхад үүний 64.7 тонн нь үндсэн ордод байгаа бол үлдсэн 62.3 тонн нь шороон ордод илэрч байгаа[5]. Одоо идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 123 уурхайгаас 117 нь шороон орд дээр тулгуурлаж байгаа бол үлдсэн 6 нь үндсэн орд ашиглаж байна. Ихэнх уурхай шороон орд ашиглаж байгаа нь шинээр үүсэж буй зах зээлийн нэгэн түгээмэл шинж бөгөөд энэ нь уул уурхайг тогтвортой хөгжүүлэх, үндсэн ордуудыг ашиглахад шаардлагатай байгаа санхүүжилтийн хомс байдалтай холбоотой юм.

[5] 2006-2008 онуудад геологи, уул уурхайн салбарын талаарх ойрийн жилүүдэд баримтлах чиглэл

Гэвч энэ нөхцөл байдал нь саяхнаас өөрчлөгдөж эхэлсэн билээ. Хэрэв 2002 онд нэг ч үндсэн ордыг ашиглаж байгаагүй бол 2003 он гэхэд 3 үндсэн орд ашиглалтад орж, 2004 онд 4 үндсэн орд ашиглахаар бүртгүүлсэн байна. Үндсэн ордыг ашиглаж эхэлсэн нь шороон ордын нөөц шавхагдаж эхэлсэнтэй холбоотой бол нөгөө талаас Монгол улсын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэний бас нэгэн илрэл юм.

Томоохон үндсэн ордын нэг болох Бороогийн алтны ордыг Бороо Голд компани ашиглаж байна. Тус ордын батлагдсан нөөц нь 35.0 орчим тонн. Тус компани нь 2003 онд 324.44 кг алт олборлосон бол 2004 онд 8.079 кг алт олборлосон байна. Бороо Голд компани нь алт олборлож эхэлсэн нь салбарын нийт алт олборлолтын хэмжээг огцом нэмэгдүүлснээр салбарын гүйцэтгэлд зарчмын нөлөө үзүүлсэн болно (Зураг 3 харна уу).

Зураг 3: Уурхай тус бүрийн нийт алт олборлолт, 2002-2004 онууд

		>100 кг	50-аас 100 кг	<50 кг
2000	Олборлолт, кг	9,564.91	887.42	1,032.4
	Уурхайн тоо	23	11	71
2001	Олборлолт, кг	10,000.67	757.62	1,334.18
	Уурхайн тоо	25	10	88
2002	Олборлолт, кг	8,417.69	940.62	1,353.2
	Уурхайн тоо	27	15	90
2003	Олборлолт, кг	7,817.57	1,413.37	1,687.65
	Уурхайн тоо	21	22	115
2004	Олборлолт, кг	16,075.74	1,000.56	1,341.7
	Уурхайн тоо	17	16	85

Хоёр дахь томоохон үндсэн орд болох Бумбат ордыг Монгол алт корпораци 2002 оны сүүлээр ашиглалтад оруулсан билээ. Тус кварцын судлын төрлийн ордын 3.0 гр/тоон бүхий агуулгатай ойролцоох нөөц нь 10 тонн бөгөөд үйлдвэрлэлийн хүчин чадал нь ойролцоогоор жилдээ 1,000 кг алт олборлох бололцоотой. Гэсэн хэдий ч одоогийн олборлолт нь 250 кг-аас хэтрэхгүй байна.

Үлдэж буй үндсэн ордууд нь үйлдвэрлэлийн эхний үе шатандаа яваа учраас тэдгээрийн олборлолт нь өчүүхэн бага юм. Эдгээрийн дундаас Сонор Трэйд компанийн ашиглаж байгаа Цагаан Чулуутын ордыг харьцангуй том гэж хэлж болох юм. Харин жилийн олборлолтын хэмжээ нь бага хэвээр байна. Тус компани нь олборлож эхэлсэн эхний хоёр жилдээ дунджаар 51.7-54.5 кг алт олборлосон байна.

2004 онд олборлосон 18.06 тонн алтыг 14 аймагт тархсан 123 албан ёсоор бүртгэлтэй алтны уурхайнууд үйлдвэрлэсэн байна. Эхний 10 том алтны компаниуд нийт олборлосон алтны 74 хувийг үйлдвэрлэсэн бол үлдэж буй 26 хувийг 113 жижиг компаниуд үйлдвэрлэсэн болно.

Хүснэгт 6: Монгол улсын алт олборлолтын хэмжээ, 1992-2004 онууд

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Алт (тн)*	0.78	1.1	1.8	4.1	5.4	8.7	10	10.1	11.4	12.06	10.71	10.84	18.06
Алт (тн)**	-	-	-	-	-	6.61	10.04	10.08	10.06	12.00	10.71	10.84	18.06

* *Засгийн газрын мэдээллийн дагуу*

** *АМГТХЭГ; 1992-1996 оны хоорондох мэдээлэл үгүй болно*

Зураг 4: Алт олборлолт, 1992-2004 онуудад



Олборлосон алтны дийлэнх хэсгийг арилжааны банкнууд худалдан авсан бол арилжааны банкнууд ихэнх тохиолдолд худалдан авсан алтаа эргүүлэн Монгол банканд борлуулж ирсэн.

1996-2001 оны хооронд тус улсад албан ёсоор үйлдвэрлэсэн бараг бүх алтыг Монгол Банк худалдан авч байжээ. Монгол Банкны жилд худалдан авсан алтны хэмжээ нь тухайн жилд албан ёсоор олборлосон алтны хэмжээнээс бага зэрэг ялгаатай байж болох боловч дээр дурдсан хугацаанд Монгол Банкны худалдан авсан алтны нийт хэмжээ мөн хугацаанд албан ёсоор олборлосон нийт алтны хэмжээтэй бараг дүйцэж байна. Түүнээс гадна Монгол Банкны жилд экспортолсон алтны хэмжээ нь тус улсын тухайн жилд олборлосон нийт алтны хэмжээтэй бараг ижил байна. Харин 2003 оноос эхлэн Монгол банкны худалдан авах алтны хэмжээ бага зэрэг багасаж эхэлсэн.

Монгол банкны худалдан авах алтны хэмжээ аажмаар буурах болсон нь 2001 онд алт олборлогч компаниуд болон арилжааны банкнуудад алтаа чөлөөтэй экспортлох эрх олгох замаар алтны зах зээлийг чөлөөлсний нэгэн илрэл юм. Хэдийгээр өнөөгийн байдлаар дийлэнх арилжааны банкнууд алтаа чөлөөтэй худалдан авч бие даан гадаадын зах зээлд шууд экспортлох эрхтэй боловч ихэнх арилжааны банкнууд худалдан авсан алтаа Монгол банканд эргүүлэн худалдсан хэвээр байгаа юм. Үүний үр дүнд алтны худалдаанаас Монгол банкны олж байсан ашгийн хэмжээ ихээхэн буурсан бөгөөд хэрэв 2002 оноос өмнө Монгол банк нэг унц алтнаас ойролцоогоор 7.15 ам.доллар олдог байсан бол өнөөдөр ердөө л 0.05 ам. доллар олдог болсон.

Өнгөрсөн таван жилийн хугацаанд Монгол улс нь албан ёсоор нийт үйлдвэрлэсэн алтнаасаа илүү алт экспортолж ирсэн. Бидний тооцоогоор алтыг илүү экспортлох

бололцоотой болсон нь нэг бол урьд жилүүдийн хуримтлалтай холбоотой байх үндэслэлтэй буюу иргэдээс хаягдал алт хэлбэрээр худалдан авсан хууль бус алт олборлогчдын үйлдвэрлэсэн алттай холбоотой болно.

Хүснэгт 7: Алтны экспорт, 1999-2004 онуудад

	1999	2000	2001	2002	2003	2004	Дүн (нийлбэр)
Алтны экспорт (тн)	12.92	11.37	10.65	12.59	12.39	19.33	79.26
Алт олборлолт (тн)	10.08	10.06	12.00	10.71	10.84	18.06	71.75
Зөрүү (тн)	2.84	1.31	-1.35	1.88	1.55	1.27	7.5

Зураг 5: Алт олборлолт болон экспортын хэмжээ



Үйлдвэрлэгчид

Монголын алт олборлолтын салбарын эрчимтэй хөгжлийн бас нэгэн нотолгоо бол сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн бэрхшээл, дэлхийн зах зээлийн тааламжтай бус нөхцөл байдал оршиж байсан зэргээс шалтгаалсан хэдий ч өнгөрсөн хугацаанд тус улсад идэвхтэй алт олборлогчдын тоо байнга өссөөр ирсэн явдал юм. Харин 2003 оноос эхлэн алт олборлогчдын тоо аажмаар буурах хандлагатай болсон. 2003 онд алтны хэд хэдэн жижиг уурхайнуудын нөөц нь шавхагдсаны улмаас хаагдсан болно. 2004 оны жилийн эцсийн байдлаар Ашигт Малтмал, Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар (АМГТХЭГ) нь алт олборлох чиглэлээр ашиглалтын 123 лицензийг 80 аж ахуйн нэгжид албан ёсоор олгожээ. Алт олборлогчдын дийлэнх хэсэг нь жижгэвтэр орд ашигладаг тул ойрын ирээдүйд идэвхтэй алт олборлогчдын тоо хорогдох хандлага хэвээр үлдэх төлөвтэй байгаа.

Хүснэгт 8: Алт олборлогчдын тоо

	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Ажиллаж буй уурхайн тоо	47	82	92	73	105	133	153	123

Эх сурвалж: АМГТХЭГ

Зураг 6: Алт олборлогчдын тоо, 1997-2005 онуудад



Эх сурвалж: АМГТХЭГ

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй компаниуд харьцангуй их байдаг хэдий ч жилээс жилд олборлосон алтны дийлэнхийг 10-аас 12 аж ахуйн нэгж үйлдвэрлэдэг байна. 2004 оны эцсийн байдлаар алт олборлолтын хэмжээний хувьд (>250кг) дараах аж ахуйн нэгжүүд багтаж байв. Үүнд: Алтан Дорнод Монгол, Бороо Голд, Монгол Газар, Шижир Алт, Гацуурт, Монполимет, Монголросцветмет, болон Эрдэс Холдинг. Эдгээр компаниуд нь 2004 онд үйлдвэрлэсэн нийт алтны 74.14 хувийг үйлдвэрлэсэн болно. Эдгээр компаниудын дундаас Бороо Голд болон Монгол Газар компани нь үндсэн орд ашиглаж байсан бол Алтан Дорнод, Шижир Алт, Гацуурт, Монполимет, Монросцветмет болон Эрдэс гэх зэрэг компаниуд нь шороон орд ашиглаж байсан юм.

Дагалдах зах зээлийн зарим нэг асуудлууд

Алт нь бэлэн мөнгөтэй дүйцэх шинж чанараараа өвөрмөц бүтээгдэхүүн тул хөгжсөн эдийн засгийн нөхцөлд идэвхтэй дагалдах зах зээлийг (derivative market) үүсгэдэг. Алтны ихээхэн хэмжээний нөөцийг үүсгэснээр барууны эдийн засагт дагалдах зах зээлийг бий болгох бололцоотой болдог. Дагалдах зах зээлийг хөгжүүлэхийн ач холбогдол нь тодорхой юм. Нэг талаас ихээхэн хэмжээний алтны нөөцтэй байсны үр дүнд нөөц эзэмшигч нь нэмэгдэл орлого олох бололцоотой болдог бол нөгөө талаас алт олборлогчид нь хэджийнгд (hedging) хамрагдах хэлбэрээр төслийн санхүүжилтийг ашиглаж шинэ уурхайг ашиглалтад оруулах бололцоотой болдог.

Алтны олборлолт тогтвортой өсөж буй нөхцөлд Монгол улс дагалдах зах зээлийг иж бүрнээр бус юмаа гэхэд дагалдах зах зээлийн зарим бололцоотой хэсгийг хөгжүүлэх бүрэн бололцоотой юм. Гэхдээ дагалдах зах зээлийг зөвхөн тодорхой хэмжээний алтны нөөц хуримтлуулсан нөхцөлд л хөгжүүлэх бололцоотой болно.

Онолын хувьд Монгол банк нь ихээхэн хэмжээний алтны нөөцийг хуримтлуулах санхүүгийн эх үүсвэртэй цорын ганц байгууллага юм. Харамсалтай нь 1992 онд төрийн өндөр албан тушаалтнууд барууны бирж дээр дилерийн тоглоомд оролцож байгаад Монгол банканд дахь алтны нөөцийг буюу ойролцоогоор 4.2 тонн алтыг бүрэн алдсанаас хойш Монгол улс нь дахин алтны нөөц хуримтлуулж чадаагүй билээ. Өнгөрсөн хугацаанд

албан ёсоор олборлосон алтны дийлэнхийг Монгол Банк худалдан авч улмаар эцсийн хэрэглэгчдэд Лондонгийн Металлын Биржийн брокеруудаар дамжуулан гол төлөв Хятад, мөн заримдаа Өмнөд Солонгос руу экспортолж ирсэн.

Өнөөгийн Монголын нөхцөлд хэрэгжүүлэх бүрэн бололцоотой дагалдах зах зээлийн хамгийн хялбар нэг хэлбэр бол энгийн тогтсон үнэ бүхий урьдчилгаа гэрээ юм. Уг гэрээний дагуу нэг тал нь тодорхой хэмжээний алтыг тохирсон хугацаанд нөгөө талдаа нийлүүлэх явдал юм. Урьдчилгаа гэрээний зарим нэг шинж нь зах зээлд хэдийнээ бий болоод байгаа юм. Тухайлбал, өнөөгийн байдлаар ихэнх арилжааны банкнууд алт олборлогчдод тодорхой хугацаанд тохирсон хэмжээний алтыг нийлүүлнэ гэсэн үндсэн дээр зээл олгож байгаа. Гэвч энэхүү бодит урьдчилгаа гэрээнээс ялгагдах гол зүйл бол алт олборлогч нь алтаар зээл авах бус харин цаасан мөнгөн хэлбэрээр зээл авч буйд оршино. Алт хэлбэрээр зээл олгох нь өнөөгийн нөхцөлд Монгол улсад хэрэгжүүлэхэд хараахан болоогүй юм. Учир нь нэг талаас зээлээр олгох алтны нөөц байхгүй бол нөгөө талаас алт хэлбэрээр зээл авсан этгээд нь алтаа борлуулах зах зээл болон холбогдох эрх зүйн орчин байхгүй байгаатай холбоотой болно. Алт хэлбэрээр зээл олгож эхлэх нь өнгөт металлын зах зээл буюу бирж хөгжүүлэхэд хүргэхийн зэрэгцээ нөгөө талаас дагалдах зах зээлийн бусад бүтээгдэхүүнийг бий болгоход хүргэх юм.

Иймээс хэрэв Монгол банк нь алтны нөөцийг бий болгож чадсан нөхцөлд бодит дагалдах зах зээлийг Монгол улсад хөгжүүлэх үйл явцад эрэгээр нөлөөлөх төдийгүй уул уурхайн салбарт нэгэн адил эрэгээр нөлөөлнө гэдэгт итгэлтэй байна.

2.4 Гянт болд болон цайрын үйлдвэрлэл

Гянт болдын үйлдвэрлэл

Хэдийгээр бүрэн судалсан хэд хэдэн гянтын орд Монгол улсын хэмжээнд байдаг ч нэгийг нь ч уурхай болгон ашиглаагүй байдаг байна. Зохих дэд бүтэц хөгжөөгүй болон дэлхийн зах зээлийн тааламжтай бус үнийн хэлбэлзэл зэрэг хүчин зүйлсүүд нь эдгээр ордыг ашиглахад саад тотгор болж ирсэн. Засгийн газрын тооцоогоор эдгээр ордуудад ойролцоогоор 63.7 мянган тонн төмөр[6] агуулагдаж байна гэж дүгнэжээ.

Олон улсын хэм хэмжээгээр бол Монголын гянтын салбарыг бараг үгүй бөгөөд МонВольфрам компанийн Цагаан Давааны гянт болдын уурхай ба ХайнарВольфрам компанийн Ховд Голын уурхай хэмээх бага оврын хоёр үйлдвэрүүд тус салбарыг төлөөлдөг байна.

Өнгөрсөн хугацаанд зөвхөн Ховд Голын уурхай дангаараа үйл ажиллагаагаа эрхлэн явуулжээ. Дэлхийн зах зээл дэх гянт болдын үнэ цэнэ нилээд буурсантай холбогдуулан бусад уурхай үйл ажиллагаагаа хаахад хүрчээ. Гянтын үнэ бага зэрэг дахин өсөхийн зэрэгцээ өмнө нь хаагдсан уурхайнууд дахин нээгдэж үйл ажиллагаагаа бага багаар явуулж эхэлжээ. 2004 онд Цагаан давааны уурхай зургаан жилийн дараа үйл ажиллагаагаа дахин эхэллээ.

2004 оны эцсийн байдлаар хоёр компанийн олборлосон гянтын хүдэр 49.5 мянган тонноос илүү гарахгүй байна.

[6] 2006-2008 онуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн ерөнхий чиг хандлага

Хүснэгт 9: Гянт болдын хүдрийн олборлолт

	2000	2001	2002	2003	2004
Гянт болдын баяжмал, 000’ тн	81.0	92.0	51.0	17.0	70.0

Эх сурвалж: АМГТХЭГ

Цайрын Үйлдвэрлэл

Монгол-Хятадын хамтарсан Цайрт Минералс компани саяхан Төмөртийн овооны цайрын уурхайн олборлолтын ажлыг 2005 оны наймдугаар сард эхэлсэн байна. Тэс уурхай Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дээр байрлах бөгөөд Сүхбаатар аймгийн Баруун урт төвөөс зүүн хойд руу 13 км-ийн зайд оршино.

Дунджаар 13.67%-н цайрын агуулгатай 70.6 сая тонн ашиглах боломжтой орд буюу 1.0 сая тонн цайр байгаа болохыг тогтоожээ. Жилдээ 300,000 тонн хүдрийг боловсруулж 70,000 тонн цайр гарган авах хүчин чадалтай гэж үзвэл тус ордын ашиглалтыг хугацаа 27 жил байх юм.

БНХАУ-аас Монгол улсад оруулсан хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалт нь Төмөртийн овооны ордыг түшиглэн үйлдвэр байгуулах, байгаа нөөцийг олборлох боломжийг нээсэн. Тус уурхайг олборлоход тулгарч буй үндсэн бэрхшээл нь дэд бүтэцтэй холбоотой. Өнөөгийн байдлаар компанийн үйл ажиллагаа жигдэрч байгаа бөгөөд эхний бүтээгдэхүүнээ экспортод ачааны машинаар хил рүү гарган борлуулж эхэлсэн. Уул уурхайн салбар болон улс орны экспортод Цайрт Минералс компанийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг одоохондоо үнэлэх болоогүй бололтой.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛДВЭРҮҮД

3.1 Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр (Эрдэнэт Үйлдвэр)

Үйлдвэрлэлийн танилцуулга

Эрдэнэт уул уурхайн корпораци буюу Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь хүдрийг ердийн ил аргаар олборлодог. Өнөөгийн байдлаар жилдээ дунджаар 25 сая тонн хүдрийн олборлолтыг хийдэг. Олборлосон хүдрийг самосвал ачигч машинуудаар баяжуулах үйлдвэрт тээвэрлэн хүдрийг үйлдвэрт 3 үе шаттайгаар конус хэлбэрийн бутлагчдаар буталж хүдрийг 15-25 рам-ын хэмжээнд хүргэдэг байна. Буталсны дараагаар хүдрийг төмөр бөмбөлгөн тээрэмд оруулж нунтаглаж дараагийн флотацийн шатанд оруулж зэсийн болон молибдены баяжмалыг гаргадаг. Үйлдвэрлэлийн эцсийн үе шат нь шүүлтүүрээр шүүж, хатаах зэргээс бүрдэнэ.

Эрдэнэтийн уурхайн үндсэн орд нь Эрдэнэт Овоо гэх газарт байдаг бөгөөд орд нь 3 давхаргаас бүрдэнэ. Хамгийн дээд давхарга нь агуулга муутай исэлдсэн хүдрээс бүрдэж байсан бөгөөд түүнийг зайлуулж уурхайн хаягдал далан болгож зүүн өмнө хэсэгт буулгаж байрлуулсан байна (Хүснэгт 1 харах). Энэхүү хаягдал исэлдсэн хүдрийн (Cu_2O) зэсийн агуулга нь 0.1% хэтэрдэггүй бөгөөд одоогоор Эрдмин үйлдвэр нь хүдэр уусгаж электролизын аргаар катодын зэсийг үйлдвэрлэн гаргаж байна. Ордын хоёр дахь давхарга нь халькоцит (Cu_2S), ковелит (CuS) болон молибденит (MoS_2) зэрэг эрдэс бодисоос бүрддэг бөгөөд үүнд зэсийн агуулга нь 0.81% болон молибдены агуулга нь 0.17% хэтрэхгүй бөгөөд энэхүү агуулгатай ордыг сүүлийн хорин жилийн турш ашиглаж дуусаад байна. Өнөөдрийн байдлаар Эрдэнэт үйлдвэр нь хамгийн доод давхарга руу ойртож байгаа бөгөөд энэ хэсэгт халькопирит ($CuFeS_2$), пирит (FeS_2) болон молибденит (MoS_2) гэх эрдсүүд байдгийн зэрэгцээ эдгээрийн агуулга нь зэсийн хувьд 0.5%, молибдены хувьд 0.17% хувьтай байна.

Тулгарч байгаа бэрхшээлүүд

Эрдэнэт үйлдвэрийн гол тулгарч байгаа бэрхшээл нь хүдрийн дундаж агуулгын хэмжээ байнга буурах болон уулын ажлын нөхцөл хүндэрч байгаад оршино. Сүүлийн 5 жилийн хугацаанд жилийн дунджаар хүдрийн агуулга нь 0.014%-иар буурч ирсэн бол 2004 оны жилийн эцэст агуулга нь 0.47% болсон байна. Үүнээс гадна хүдэрт агуулагдаж буй үндсэн эрдэс бодис нь илүү нарийн ширхэгтэй болсноор үйлдвэрлэлийн процессыг удаан болгох болон үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлж байна. Өнөөдрийн байдлаар хүдрийн гарцын үзүүлэлт нь 88%-иас давахгүй байна.

Хүснэгт 10: Агуулга

Агуулга, %	1999	2000	2001	2002	2003	2004
Зэс	0.697	0.68	0.677	0.647	0.613	0.59
Молибден	0.0197	0.0194	0.02	0.0197	0.0202	-

Эх сурвалж: ЭУБҮ

Мөн уурхайн гүний хэмжээ нь далай төвшнөөс 1,150 метрт хүрч байгаа нь хүдрийн тээвэрлэлтийн зайг уртасгаж, үүнээс үүдэн гарч байгаа бүтээгдэхүүний зардал ихсэж байгаатай холбоотой. Эрдэнэт үйлдвэрийн удирдлагын үзэж байгаагаар өнөөдрийн нөхцөлөөр ордыг цаашид ашиглах тохиолдолд 3-4 жилийн дараа уурхай ашиггүй болж хувирах магадлал ихтэй юм.

Зураг 7: Эрдэнэтийн уурхай



Эх сурвалж: Эрдэнэтийн үул уурхайн корпораци

Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд одоо хэрэглэж буй цахилгааны өндөр үнийг бууруулах чухал асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болоод байна. Хэрэглэж байгаа цахилгааны ихэнхийг төвийн эрчим хүчний системээс авдаг. Цахилгааны үлдэх хэсгийг Оросын Холбооны улсаас авдаг. Өнөөдрийн байдлаар үйлдвэрлэлийн нийт зардлын 28%-ийг цахилгаан эрчим хүчний өртөг эзэлж байна. Эрдэнэт үйлдвэрийн удирдлага Монгол улсын Засгийн газарт Эрдэнэт хотын дулааны станцыг шинэчлэх замаар түүний хүчин чадлыг 100 мВт хүргэж эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах тухай асуудлыг удаа дараа тавьсан. Харамсалтай нь энэ асуудал одоог хүртэл нааштайгаар шийдэгдээгүй. Хямд эрчим хүчийг орон нутгийн станцаас авснаар Эрдэнэт үйлдвэр нь үйлдвэрлэлийн өртгийг мэдэгдхүйц хэмжээгээр буулгах боломжтой юм.

Төлөвлөгөө

Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэрийг цаашид тогтвортой ажиллуулах зорилгоор үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийг төлөвлөж байгаа бөгөөд үүнийг гидро-металлургийн өргөтгөл байгуулснаар хийх боломжтой гэж үзэж байна. Мөн үйлдвэрлэлийг өргөжүүлэх хөтөлбөрийн хүрээнд саяхан молибдены баяжмалыг гаргах, боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулаад байна. Энэхүү үйлдвэр нь 2005 оны 9-р сарын 5-нд ашиглалтад орсон юм. Үйлдвэрлэлийн төлөвлөж байгаа хүчин чадал нь жилдээ 1,800 тонн молибден болон 1 тонн ренийн баяжмалыг боловсруулан гаргах юм.

Эрдэнэт үйлдвэр нь 2005-2015 онуудад үйлдвэрийг хөгжүүлэх хэтийн чиглэлийг тодорхойлох ажлыг хийж байгаа бөгөөд энэ нь зэсийн катод болон электродыг үйлдвэрлэх боломжийн тухай сүүлийн үед гадаадын компаниудаар хийсэн судалгаанууд дээр үндэслэх юм. Эрдэнэт үйлдвэрийн удирдлагын ярьснаар гидро-металлургийн иж бүрэн цогцолборыг байгуулахад урьдчилсан байдлаар хийгдэх бүх төрлийн лабораторийн

судалгаануудыг бүрэн хийсэн байгаа юм байна. 2005 оны 10-р сарын сүүлээр үйлдвэрийг дараагийн 10 жилд хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг хувь нийлүүлэгчдэд танилцуулахаар бэлдэж байгаа юм байна. Энэхүү боловсруулсан төлөвлөгөөгөөр Эрдэнэт үйлдвэр нь 80,000 тон зэс үйлдвэрлэх хүчин чадалтай 2 нэмэлт гидро-металлургийн үйлдвэрийг байгуулах юм байна.

Эхний үйлдвэр нь SX/EW буюу электролизын аргаар уусмалаас зэсийг баяжуулж гаргах технологиор 10,000 тонн катодын зэсийг үйлдвэрлэх юм. Энэ аргаар боловсруулалт хийхэд Эрдэнэт үйлдвэрт 400 гаруй сая тонн доош агуулгатай хаягдал хүдрийн нөөц байгаа юм. Энэ үйлдвэрийг байгуулах талаар хэд хэдэн хөрөнгө оруулагчидтай хэлэлцээрүүдийг эрчимтэй ярьж эхлээд байна.

Сонирхож байгаа хөрөнгө оруулагчдын нэг нь Самсунг корпораци байгаа бөгөөд энэхүү корпораци нь Эрдэнэт үйлдвэртэй хамтран SX/EW үйлдвэрийг байгуулах талаар өөрийн талаас сонирхлоо илэрхийлээд байгаа юм байна. Энэхүү үйлдвэрийг барихад гол эрсдэлтэй байгаа зүйл нь цаг агаарын эрс хүйтэн нөхцөл юм. Өвлийн эрс хүйтэн улирал нь боловсруулалтын процесст хэрэглэгддэг бактерийг бүрэн хэмжээгээр хөдөлгөөнгүй болгосноор уусмалаас зэсийг гаргах ажиллагааны үр дүнг 0%-д хүргэж болзошгүй юм.

Боловсруулж байгаа төлөвлөгөөний нэг хэсэг нь хүдэрт агуулагдаж байгаа сульфидыг хайлуулах зорилгоор өндөр температур болон даралт ашиглан автоклавын технологиор зэсийн баяжмалыг гаргах ба SX/EW технологийг ашигласнаар нэмэлт 20,000 тонн катодын зэсийг үйлдвэрлэх явдал юм. Иймд SX/EW үйлдвэр нь нийтдээ жилд 30,000 тонн катодын зэсийг гаргах боломжтой болох юм. Энэхүү аргаар катодын зэсийг үйлдвэрлэх боломжийн талаарх ажлыг Канадын Caminco компани хийж байгаа юм байна.

SX/EW үйлдвэрлэлийг байгуулахад нийт 60-70 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Энэхүү SX/EW үйлдвэрлэлийг байгуулахад Эрдэнэт үйлдвэр нь Өмнөд Солонгосын Самсунг корпорацитай хамтрах магадлал ихтэй байгаа бөгөөд энэ тохиолдолд Эрдэнэт үйлдвэр хамтарсан үйлдвэрийн 51%-ийг, Солонгосын тал 48%-ийг эзэмших болов уу. Эрдэнэт үйлдвэр нь энэхүү үйлдвэрийг барих ажиллагааг 2006 онд эхэлж ашиглалтад 2008 онд оруулахаар төлөвлөж байгаа юм байна. Эрдэнэт үйлдвэрийн удирдлагын ярьснаар бол оруулсан хөрөнгө оруулалтын буцаан төлөх хугацаа нь 2.5 жил байх юм.

SX/EW үйлдвэрийг барихын зэрэгцээ Эрдэнэт үйлдвэр нь гидро-зэсийн технологийн аргаар 50,000 тонн зэсийн цувималыг үйлдвэрлэн гаргах гидро-металлургийн иж бүрдэл цогцолборыг байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү үйлдвэр нь туршилтын технологийг нэвтрүүлэх бөгөөд энэ нь Эрдэнэт үйлдвэрээс гаргасан зэсийн баяжмалыг ердийн даралтын дор уусгаж зэс утсыг үйлдвэрлэх юм.

Өнөөдрийн байдлаар Эрдэнэт үйлдвэр нь гидро-зэсийн технологи дээр суурилуулсан үйлдвэрийг байгуулах худалдааны талын асуудлыг энэхүү технологийн патентыг эзэмшиж буй Финлянд улсын Outokumpu компанитай хэлэлцээрээ явуулж байна. Мөн Outokumpu компани нь зэс утсыг Эрдэнэтийн зэсийн баяжмалаас үйлдвэрлэн гаргах тухай судалгааг хийж байна.

Зураг 8: Стратеги төлөвлөгөөний бүдүүвч



Тайлбар:

Одоогийн үйлдвэрлэл
Төлөвлөгөө
Си болон Мо баяжмал
Хүдэр олборлолт

Дээр дурьдсан төлөвлөгөөнүүдийг биелүүлэхэд гарах гол хүндрэл бол үйлдвэрүүдийг байгуулахад шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэрүүдийг шийдэх асуудал юм. Эдгээр үйлдвэрүүдийг барихад ойролцоо 207-230 сая ам. долларын хөрөнгө оруулалтыг хийх санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй байна. Монголын Засгийн газар нь Эрдэнэт үйлдвэрийн хамгийн том хувьцаа эзэмшигч бөгөөд үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах ажиллагааг дэмжих төсөл дээр хэзээ ч санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаагүй юм байна. Иймд гидро-металлургийн хоёр үйлдвэрийг байгуулахад шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг хамтарсан үйлдвэр байгуулснаар шийдэх болов уу.

Мөн шийдвэр гаргах үйл ажиллагаа нь дандаа бэрхшээлтэй тулгарч байгаа учир нь гэвэл одоогийн байгаа эзэмшлийн бүтэц, зохион байгуулалт дээр тулгуурласан уян хатан бус удирдлагын системээс болдог. Шийдлийг хурдан хугацаанд гаргах шаардлагатай асуудал дээр хоёр талын зөвшөөрлийг авах гэж ихэнхдээ удаж, хожуу шийддэг.

3.2 Эрдмин үйлдвэр

Эрдмин үйлдвэр нь электродын аргаар уусмалаас баяжуулах (SX/EW) технологиор эрс хүйтэн цаг агаарын нөхцөлд ажиллаж чаддаг содон онцгой үйлдвэрийн нэг юм. SX/EW технологи нь АНУ, Австрали болон Өмнөд Африк гэсэн цаг агаарын зөөлөн нөхцөлтэй орнуудад зориулж катодын зэсийг үйлдвэрлэхэд анх боловсруулсан аргачлал юм. Зөөлөн цаг агаартай нөхцөлд технологид ашиглагдаж байгаа бактерийн идэвхжилт нь сайн явагддаг бөгөөд энэ нь уусмалаас баяжуулах үйл ажиллагааг өндөр зэрэглэлд явуулж чаддаг ба үйлдвэрлэлийн бүтээмжийг өндөр байлгах боломжтой болгодог.

Өнөөдрийн байдлаар Эрдмин үйлдвэр нь эрс хүйтэн цаг агаар болон далай төвшнөөс 1,500 метрийн өндөрт байрлан ажиллаж байгаа дэлхийн цорын ганц гидро-металлургийн үйлдвэр болно. Компанийн үйлдвэрлэлийн хэмжээ нь харьцангуй бага байгаа боловч хүйтний нөхцөлд SX/EW технологиор үйлдвэрлэлийг явуулах талаар хуримтлуулсан туршлага болон хийсэн судалгаа, ажиглалтууд нь Монголын цаашдын ирээдүйн зэсийн үйлдвэрлэлийн хөгжилд асар их ач холбогдолтой юм.

Товч түүх

Эрдмин компани анх 1995 онд байгуулагдахдаа Монгол-Америкийн хамтарсан компани гэж байгуулагдаж, Монголын талаас Эрдэнэт үйлдвэр, Америкийн талаас RCM Inc. гэж компани үүсгэн байгуулсан юм. Эрдмин үйлдвэрийг байгуулахдаа Эрдэнэт үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт концерноор дамжуулан борлуулах үнэ өндөртэй бүтээгдэхүүн гаргах зорилго тавьсан юм. Мөн чухал зорилгуудын нэг бол цаг агаарын хүйтний нөхцөлд электродын аргаар уусмалаас баяжуулалтыг хийх боломжийг турших байсан юм. Үйлдвэрийг байгуулах боломжтой эсэх талаар хийсэн судалгааны ажил болон SX/EW үйлдвэрийг барих ажлын санхүүжилтийг Японы Марубени корпорациас зээл авах замаар хийсэн бөгөөд нийт зээлийн хэмжээ 7 сая ам.доллар байсан байна.

Эрдмин компанийг байгуулсны дараа удалгүй RCM Inc. компани нь Эрдмин компанийг эзэмшдэг өөрийн хувьцаагаа Nescor Minerals гэж компанид худалдсан юм. Иймд Nescor Minerals компани нь шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах, нийлүүлэх ажлыг гүйцэтгэж, Marubeni Trading House-ээс авсан зээлээ Nescor Minerals өөрийн банкны дансандаа шилжүүлэн авсан байна. Nescor Minerals-ын худалдаж авсан тоног төхөөрөмж нь үнэтэй байгаагүй ч тус компанийн удирдлагын мэдээлснээр бүх авсан зээл нь тоног төхөөрөмж болон тээврийн зардалд зориулагдсан гэсэн байна.
1997 онд үйлдвэр ашиглалтад оруулахад бэлэн болсон байхад Nescor Minerals өөрийн хувьцаагаа Австралийн Armada Gold гэж компанид худалдсан байна. 1998 онд Armada Gold компани нь Эрдмин үйлдвэрийг ашиггүй хамтарсан үйлдвэр гэж үзэж өөрийн хувьцаагаа Америкийн Capital Resource Mining гэх компанид худалдсан байна. Ингээд Capital Resource Mining гэж компани нь Эрдмин үйлдвэрийн 49%-ийн эзэмшигч болсон юм.

Компанийн хувьцаа нь ойр ойрхон нэг компаниас нөгөө компани руу шилжиж байсан байдал нь Эрдмин үйлдвэрийг ганцаардуулж 1997 оны эцэст нийт 9 сая ам.долларын их хэмжээний өртэй үйлдвэр хоцорсон юм. Энэхүү байдал нь үйлдвэрийн үйл ажиллагаанд маш муугаар нөлөөлсөн гэж хэлж болохоор байна.

Тус үйлдвэрийн Монгол талын хувьцаа эзэмшлийн хувьд Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр болон MICO Holding компанийн хооронд маргаан гарчээ. Энэ нь MICO Holding гэж компани өөрийгөө Эрдэнэт концерн компанийн хуулийн үндэслэлтэй залгамжлагч гэсэн үүдэлтэй маргаан байв. Эрдэнэт Үйлдвэрийн дээд удирдах албан тушаалтнууд Эрдэнэт концерныг үүсгэн байгуулж, улсын Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгийг зохистой бус хэлбэрээр ашиглах замаар өөр дээрээ шилжүүлж авсан байна гэсэн шалтгаанаар өнгөрсөн хугацаанд Эрдэнэт концерныг бизнес явуулах нэгжийн хувьд татан буулгасан юм.

Өнөөдрийн байдлаар Эрдмин үйлдвэрийн хувьцааг CRM (65%), Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр (25%) болон MICO Holding (10%) зэрэг компаниуд эзэмшдэг байна.

Эрдмин үйлдвэр катодын зэсийг үйлдвэрлэхэд шаардагдах хүдрийг бэлтгэх зорилгоор хаягдал хүдрээ тусгайлан овоолж эхэлсэн бөгөөд хүдрийн дээд агуулга нь 0.59%-тай ба ихэнхдээ халькопирит ($CuFeS_2$), халькоцит (Cu_2S) гэсэн эрдсийн агуулгатай байжээ. Эхний

хүдрийн овоо нь 2,545.0 мянган тонн байсан бол энэ нь 28.5 мянган тонн зэсийн агуулгатай байсан юм. Энэхүү хүдрийн овоог 2004 он хүртэл идэвхтэй ашиглаж ирсэн байна. Ганц овоолгыг зогсоо зайгүй ашиглаж ирсний улмаас хүхрийн хүчил катализатрын үүрэг гүйцэтгэх шаардлагатай бактерийг устгаж, улмаар энэ нь исэлдэх чадварыг бууруулсан юм. Иймд нэг овоолгыг зогсоо зайгүй ашигласнаас болж уусмалаас гаргаж авах зэсийн хэмжээ эрс буурч, зэс үйлдвэрлэлийн хэмжээ үүнийг дагаад багассан байна.

2004 онд Эрдмин үйлдвэр нь хоёр дахь овоолгыг байгуулж дууссан бөгөөд хоёр дахь овоолгыг ашиглалтад оруулснаар овоолгыг сэлгэн ашиглах бололцоотой болсон нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлсөн юм. Хоёр дахь хэсгийн овооны хүдрийг ашиглаж эхэлснээр шүүлтүүрийн процессыг эргэлтийн системд оруулах боломжтой болсон бөгөөд металл гаралт нь сайжирсан байна. Хүдрийг ашиглах эргэлтийн системийг хэрэглэснээр үйлдвэр нь зэсийн гаралтын буурч байгаа үзүүлэлтийг зогсоож, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болоод байна. Өнөөдрийн байдлаар Үйлдвэр нь 2.45 мянган катодын зэсийг үйлдвэрлэж байна.

Хүснэгт 11: Катодын зэсийн үйлдвэрлэлт, 1997-2004 онуудад

	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Катодын зэс, тн	2,757.57	2,319.88	1,534.89	641.38	1,475.98	1,469.02	1,160.09	2,451.07

Эх сурвалж: АМГТХЭГ

Тулгарч буй бэрхшээлүүд

Катодын зэсийн үйлдвэрлэл 1997 онд эхэлсэн. Үйлдвэрлэл эхэлснээс хойшхи хугацаанд зэсийн үйлдвэрлэл нь тогтворгүй байдалтай байна. 1997 онд Эрдмин үйлдвэр нь 2,757.6 тонн зэсийн катод үйлдвэрлэсэн байна. Эхний жилийн харьцангуй өндөр бүтээмж нь агуулга сайтай хаягдал хүдэр ашигласнаас шалтгаалсан байна. Дараагийн жилүүдэд үйлдвэрлэлийн бүтээмж буурсан явдал нь гидро-металлургийн үйлдвэрийг ажиллуулах туршлага дутсан болон шаардлага хангасан хүдэр дутсанаас болсон. Компанийн удирдлагын үзэж байгаагаар үйлдвэрийн хүчин чадал буурсан технологийн талын үндсэн шалтгаанууд нь:

- Хаягдал хүдрийг газар зүйн болон бүтцийн байдлаар буруу овоолсон[7]
- Хэт их овоолсноос болоод хүдрийн доод хэсэгт хүрэхэд хүндрэлтэй байсан
- Исэлдэх процесст шаардагдах хүдрийн агааржуулалтыг муу хийж байсан
- Эхний хүдрийн овоонд байнгын хүхрийн хүчлийг хэрэглэж байсан нь хүдрийн бүтцийг буруугаар нурааснаас болж хүхрийн хүчил нь доод давхаргат хүрсэн байдал
- Шүүлтийг хийх талбайн хэмжээ хязгаарлагдмал байсан гэх мэт болно.

Өөр нэг хүндрэлтэй байгаа зүйл бол Эрдэнэт үйлдвэрээс хамаарч байгаа байдал. Үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардагдах эрчим хүч, ус болон уурын хэрэгцээг Эрдмин үйлдвэр өөр нэгэн сонголтгүйгээс болоод Эрдэнэт үйлдвэрээс авч байна. Эдгээр хэрэгцээний цорын ганц нийлүүлэгч болох Эрдэнэт үйлдвэр нь Эрдминд өөрийн тогтоосон үнийг тулгалтын журмаар тогтоогоод байна. Эрдмин үйлдвэр нь хэрэгцээнийхээ эрчим хүч, уур болон усыг зах зээлийн үнээс 40 дахин илүү үнээр худалдан авч байна.

[7] Хүдрийн овооны дээд цэг нь бусад орнуудынхтай харьцуулахад хоёр дахин өндөр байна

Төлөвлөгөө

Компанийн үндсэн гол зорилго нь катодын зэсийн үйлдвэрлэлийг тогтвортой байдлаар явуулах бөгөөд нийт бүтээгдэхүүний хэмжээг ихэсгэж, үйлдвэрлэлийн төлөвлөгдсөн хүчин чадлын хэмжээнд хүргэхэд оршино. Мөн үүний зэрэгцээ, борлуулалтын өртөг өндөртэй бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд үйлдвэр нь саяхнаас зэс утсыг үйлдвэрлэж эхлээд байна. Энэхүү бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь компанийн санхүүгийн байдлыг мэдэгдхүйц сайжруулаад байна.

Гэхдээ тус үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх асуудал нь Эрдмин үйлдвэрийг хаягдал хүдрийн нөөцөөр хангах Эрдэнэт үйлдвэрийн шийдвэрээс шалтгаалаад байна. Хэрэв Эрдэнэт үйлдвэр нь өөрөө тусдаа SX/EW үйлдвэрийг байгуулахаар шийдэх юм бол Эрдминд хаягдал хүдэр өгөх асуудал боломжгүй болно. Илүү өндөр чадалтай SX/EW үйлдвэрийг байгуулах асуудлын талаарх Эрдэнэт үйлдвэрийн гарах шийдэл тодорхой бус байгаа байдал нь Эрдмин үйлдвэрийг цаашид хөгжүүлэхэд саад болж байна.

3.3 Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр (ДТҮ)

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр (ДТҮ) нь Японы Экспорт-Импорт банкны зээлээр баригдсан. Зээлийг Иточу Худалдааны компаниар дамжуулан авсан болно. Үйлдвэрийн барилгын ажил 1990 онд эхэлсэн бөгөөд эхний хайлуулалтын цэх 1993 онд ашиглалтад орсон. 1994 он гэхэд тус үйлдвэрийн барилгын ажил бүрэн хэмжээгээр дууссан байсан. Өнөөгийн өрсөлдөөнтэй зах зээл дээр иймэрхүү ижил төстэй металлургийн үйлдвэрийг барихад 40-45 сая ам.доллар шаардагдаж байхад ДТҮ-ийг 80-аас дээш сая ам.доллараар босгосон байна. Иймээс өнөөг хүртэл энэхүү их хэмжээний өр нь тус үйлдвэрийн үйл ажиллагаанд муугаар нөлөөлж байна. Тус үйлдвэр дээр суурилагдсан тоног төхөөрөмжийг Mitsubishi Heavy Industries компаниас худалдаж авсан. Үйлдвэрийн төлөвлөгдсөн хүчин чадал нь жилдээ 100.0 мянган тонн төмрийн бүтээгдэхүүн гаргах. Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр нь 100%-ийн улсын эзэмшлийн үйлдвэр юм. Өнөөдрийн байдлаар ДТҮ нь төмөр үйлдвэрлэж гаргадаг ганцхан пиро-металлургийн үйлдвэр юм.

Үйлдвэрлэл

ДТҮ нь гурван үндсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үүнд:

- Төмөр арматур (10-аас 40 мм диаметртэй болон 3.5-аас 12 метрийн урттай)
- Төмөр булан (ихэнхдээ 25х25 мм болон 45х45 мм-ийн хэмжээтэй)
- Төмөр бэлдцүүд (115х115 мм хэмжээтэй болон 2-оос 3 метрийн урттай)

Үйлдвэрээс 25-аас 27 нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүн гардаг бөгөөд энэ нь голдуу янз бүрийн хэмжээтэй төмөр арматур болон булангууд болно. Төмөр бэлдцүүдийг ихэнхдээ экспортод гаргадаг бол арматур болон булангуудыг дотоодын зах зээлийн хэрэгцээнд үйлдвэрлэдэг юм байна. Үйлдвэрлэлийн нийт процесс нь хаягдал төмрийг дахин боловсруулах явдал юм. Хаягдал төмрийг боловсруулах технологийн процесс нь гурван үе шаттайгаар явагдах бөгөөд энэ нь хаягдал төмрийг Electric Arc Furnace (EAF) гэх цахилгаан зууханд хайлуулах, үргэлжлүүлэн хэвлэх болон цувих процесс юм. Үйлдвэрлэлийг жилийн туршид тасралтгүй явуулахын тулд ажлыг гурван ээлжээр зохион байгуулсан байна.

Зураг 9: Технологийн бүдүүвч



2004 онд ДТҮ нь 54.51 мянган тонн төмрийн бэлдэц болон 28.94 мянган тонн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Өнөөгийн байдлаар ДТҮ нь нэг ээлжид 300 тонн арматур, 300 тонн булан болон 250 тонн бэлдцийг үйлдвэрлэж байна.

Хүснэгт 12: ДТҮ-ийн үйлдвэрлэлт, 2002-2005 онуудад

Бүтээгдэхүүн	2000	2001	2002	2003	2004	2005*
Эцсийн бүтээгдэхүүн, 000’ тн	7.4	7.2	10.4	20.62	28.94	40.0
Ган бэлдэц, 000’ тн	13.0	10.0	15.9	39.11	54.51	20.0

** Тусгал тооцоо*
Эх сурвалж: ДТҮ

Тулгарч байгаа бэрхшээлүүд

2003 он хүртэл ДТҮ-ийн үйлдвэрлэлийн ажиллагаа ашиггүй үзүүлэлттэй явж иржээ. Мөн 1990 онуудад ДТҮ нь арилжааны банкнуудын дунд хамгийн найдваргүй зээлдэгч гэгдэж, их хэмжээний алдагдалтай ажиллаж байсан тул ямар ч банк зээлийг нь сунгахгүй болсноор 2002 онд нийт алдагдал нь 3.0 тэрбум төгрөгт хүрсэн юм. Монросцветмет компанийн лоббидсоны үр дүнд 2002 онд менежмент болон хэтийн төлөвлөлтийн асуудлыг Монросцветмет компанид шилжүүлсэн. Энэхүү алхам нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлсөн. Энэхүү өөрчлөлтийг хийсний үр дүнд Монросцветмет компани нь батлан даалт гаргаснаар банкнууд дахин зээл олгож эхэлсэн бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн капиталыг нэмэх, улмаар зардлыг багасгах болон удирдлагын төвшинг сайжруулахад чиглэгдэн зарцуулагдсан байна. Иймд 2004 онд ДТҮ-ийг ажиллуулж эхэлснээс хойш анх удаа ашигтай ажилласан үзүүлэлттэй гарч, ашгийн хэмжээ нь 3.2 тэрбум төгрөг болсон байна.

ДТҮ-ийн менежментийг Монросцветмет компанид шилжүүлэх урьдын шийдвэрийг Төрийн Өмчийн Хорооны шинээр гарч ирсэн удирдлагууд дэмжээгүй бөгөөд 2005 онд үүнийг буцаасан байна. Монросцветмет-ийн дээд удирдлагын үйл ажиллагаанд итгэхгүй байна гэсэн үндэслэлээр энэхүү шийдвэрийг гаргасан байна.

Өнөөдрийн байдлаар тулгарч байгаа гол хүндрэл бол хаягдал төмрийн нөөцийг бий болгох асуудал юм. Сүүлийн гурван жилд хаягдал төмрийг эрчимтэй гадаадад экспортоор гаргасан нь тус үйлдвэрийн үйл ажиллагаанд муугаар нөлөөлж байна. Гадагшаа гаргаж байгаа төмрийн хэрэгцээ эрс нэмэгдсэнээс болж төмрийн үнийг хөөрөгдүүлэхэд хүргэж, 2002 онд хаягдал төмрийн үнэ ойролцоогоор 30.0 мянган төгрөг (26.6 ам.доллар) байсан бол 2004 оны сүүлчээр үнэ нь өсөж 100.0 мянган төгрөг (83.3 ам.доллар)-т хүрсэн байна. ДТҮ-ийн удирдлагын үзэж байгаагаар хаягдал төмрийн нөөц нь хязгаарлагдмал байгаа бөгөөд Хятад улс руу эрчимтэй хэтрүүлэн гаргаж байгаа байдал нь хаягдал төмрийн нөөцийг ерөнхийдөө үгүй болгосон байна.

Хүснэгт 13: Хаягдал төмрийн экспорт, 2002-2005 онууд

	2002	2003	2004	07-2005
Хаягдал төмөр, тн	3,000.0	4,075.1	20,330.4	4,941.0

Эх сурвалж: ГЕГ

Зураг 10: Хаягдал төмрийн экспорт, 2003-2005 онууд



Үйлдвэрийн хувьд түүхий эдийн үнэ нэмэгдэж байгаа байдал нь бүтээгдэхүүний өртөгт муугаар нөлөөлж, үйлдвэрлэлийг ашиггүй болгоход хүргээд байна. Урьд өмнө нь бүтээгдэхүүний үнэ эрс нэмэгдээгүй байсан үед ч хятадын үйлдвэрлэлийн үнэтэй өрсөлдөхөд хэцүү байсан бол энэ байдал өнөөдрийн хувьд улам хүндрэлтэй болж байна. Иймд хаягдал төмрийн нөөцтэй болох асуудал нь үйлдвэрлэлийн хувьд хамгийн том бэрхшээл болоод байна.

Төлөвлөгөө

Хаягдал төмрийн нөөцийн дутагдалтай байгаа бэрхшээлийг даван шийдэх зорилгоор ДТҮ нь үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийн хувьд өөрчилж төмрийн хүдэр боловсруулах хэтийн чиглэлтэй байгаа боловч энэ нь өнөөдрийн байдлаар зөвхөн санаа бодлын төвшинд байгаа бөгөөд энэ талаар нарийн судалгаа болон төлөвлөлтийг боловсруулж гаргаагүй байна.

ДТҮ-ийг байгуулахаар анх төлөвлөж байхад үйлдвэрийг Дархан хотын ойролцоо байрлах хэд хэдэн төмрийн ордыг ашиглаж төмрийн бүтээгдэхүүн гаргах боломжтой гэсэн үндсэн дээр тус үйлдвэрийн эзэмшилд дараах төмрийн хүдрийн ордуудыг оруулан бүртгүүлсэн байна. Үүнд:

- Төмөр Толгойн Орд, Дархан хотоос 35 км (батлагдсан нөөц нь ойролцоогоор 21.35 сая тонн төмрийн хүдэр)
- Төмөртэйн Орд (тооцогдож байгаа нөөц нь 50.2 сая тонн төмрийн хүдэр)
- Баян Голын Орд (тооцоологдож байгаа нөөц нь 132.0 сая тонн хүдэр)

Ашигт малтмалын хууль гарч хэрэгжиж эхэлсэн 1997 он хүртэл эдгээр гурван орд нь ДТҮ-ийн эзэмшилд байсан байна. Энэ үед компани нь санхүүгийн хүнд байдалд орсны улмаас дээрх ордуудыг үлдээж чадаагүй бөгөөд 1997 оны сүүлд лицензээ худалдаачдад алдсан (Хуулийн 14-р зүйлийн үндэслэлээр "Эхэлж ирсэнд – Эхэлж үйлчилнэ") байна. Лицензийг анх авсан эзэмшигчид нь Хятадын худалдаачдад борлуулсан байна. Засгийн газрын ихэнх ажилтнууд Ашигт малтмалын хуулийн үр дүнг эерэгээр тайлбарлаж байгаа боловч экспортын боломж ихтэй улсын хэдхэн үйлдвэрүүдийн нэг болох ДТҮ-т Ашигт малтмалын хууль нь муугаар нөлөөлсөн гэж хэлэх боломжтой. Мөн хуулийн хувьд ярихад хууль нь өөрөө чанар муутай боловсруулагдсан биш харин Засгийн газар нь хуулийг улсын үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай муу уялдуулан зохицуулж хэрэгжүүлсэн байна.

Саяхан болтол ДТҮ нь дээрх дурьдсан лицензийн талаарх маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр хөөцөлдөж байсан бөгөөд эдгээрээс нэгийг л буцааж авах боломжтой болсон. 2005 оны 9-р сарын эхэнд Дээд Шүүхийн шийдвэрийн тогтоол нь ДТҮ-ийн талд гарч Төмөр Толгойн ордын эзэмшигчээр ДТҮ болсон байна.

Иймд ДТҮ нь өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөтгөн Төмөр Толгойн ордыг ашиглан хүдэр боловсруулж төмрийн бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байна. Урьдчилан тооцоолж гаргасан хөрөнгө оруулалтын хэмжээг ямар үндэслэлтэйгээр гаргасан нь тодорхой биш байгаа боловч үйлдвэрийн дээд удирдлагын үзэж байгаагаар энэхүү төслийг хэрэгжүүлэхэд 150-200 сая ам.долларын санхүүгийн хөрөнгө шаардлагатай байгаа юм байна. ДТҮ-ийг тогтвортой ажиллуулахад энэхүү төсөл нь чухал ач холбогдолтой болоод байна. Хүдэр боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиолдолд үнийн хувьд өрсөлдөх чадвартай болохоос гадна нийт үйлдвэрлэлийн хэмжээг мэдэгдхүйц өсгөх бүрэн боломжтой болох юм.

Бусад үлдэж байгаа хоёр ордын хувьд гэвэл Төмөртэйн ордын шинэ лиценз эзэмшигч болох BLT компани нь ашиглалтыг явуулж байна. BLT компани нь ордыг ашиглаж эхлэхийн тулд Хятад талаас хөрөнгө оруулалт авсан бөгөөд 2004 оны сүүл гэхэд 31.5 мянган тонн хүдрийг олборлосон байна. Өнөөдрийн байдлаар BLT компани нь өдөртөө 325 тонн төмрийн хүдэр олборлож, үүнийг бүгдийг нь боловсруулаагүй түүхий байдлаар Хятад руу ачуулан явуулж байна.

Баянголын орд нь мөн л хувийн хэвшлийнхний гарт орсон байна. Баянгол ордын өнөөдрийн эзэмшигч нь махны худалдааны томоохон компаниудын нэг болох Дорнын Говь компани бөгөөд орон нутгийн төрийн байгууллагуудаас орд дээр ямар нэгэн хөрсний ажил явуулж буй мэдээ батлагдахгүй байгааг бодоход энэ орд худалдаалагдахаар төлөвлөгдөж байж болзошгүй юм. Батлагдсан эх сурвалжийн мэдээллээс үзэхэд Засгийн газар нь ордыг буцаан авах тухай сул ярианаас болж ордын өнөөгийн эзэмшигч нь худалдан авагчийг идэвхтэй хайж байгаа юм байна.

3.4 Монголросцветмет нэгдэл

Монголросцветмет нэгдэл нь Монгол улсын хоёр дахь том уурхай болно. Энэхүү нэгдэл нь 1973 онд Монгол-Оросын хамтарсан үйлдвэр гэж байгуулагдаж, Монголын Засгийн газар 51 хувийг, Орос улсын Засгийн газар 49%-ийн эзэмшлийг тогтоосон байна. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь жонш олборлох бөгөөд энэ нь компанийн 85%-ийн орлогыг бүрдүүлдэг юм байна. Жоншны уурхайгаас гадна компани нь нүүрсний жижиг уурхайтай бөгөөд энэ нь голдуу өөрийн хэрэгцээний нүүрсийг олборлохоос гадна жижиг оврын алтны уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна. Тус нэгдлийн хувьд борлуулалтын өндөр өртөгтэй

жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломжтой байгаа бөгөөд энэхүү баримтын гол зорилго болж буй үнэт металлын судалгааг л зөвхөн хамруулсан болно.

Алтны үйлдвэрлэл

Монголросцветмет нь алт олборлолтын урт түүхтэй байгууллага мөн. Хуучин цагийн үед Монголросцветмет нь Монголын хамгийн том алт олборлогч байсан. Саяхан хүртэлх хугацаанд нэгдэл нь Монголын хамгийн том алтны шороон орд болох Толгойтын ордын ашиглалтыг (батлагдсан нөөц нь 23 тонн алт) явуулж ирсэн. 2000 он гэхэд Толгойтын ордын алтны нөөц дуусаж байгаатай холбогдуулан буурч, урьд өмнө нь ашиглаж байсан ордуудаа өөрийн охин болох Шижир Алт компанид шилжүүлэн өгсөн байна.

Зэрэгцээ ордын алтны нөөц

Өнөөдрийн байдлаар Монголросцветмет нэгдэл нь бие дааж Төв аймгийн нутаг дэвсгэр дэх Заамарын алтны газар дээр олборлолт явуулж байгаа бөгөөд энэхүү газрыг Зэрэгцээ орд гэж нэрлэж дадсан байна. Зэрэгцээ ордын алтны батлагдсан нөөц нь бага бөгөөд ойролцоогоор нэг тонн алт юм. 2005 он гэхэд энэ ордын нөөц дуусахаар байна. Зэрэгцээ ордын алтны олборлолт нь өнөөдрийн байдлаар жилдээ 250 кг-аас хэтрэхгүй байна. Зэрэгцээ ордын ойролцоо орчимд алтны агуулга сайтай ордыг нээх хайгуулын ажил явагдаж байгаа хэдий ч тус нэгдэл нь жоншны олборлолтод илүү анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 14: Монголросцветмет нэгдлийн алт олборлолт

	2000	2001	2002	2003	2004
Алт олборлолт, кг	160.13	-	56.7	236.1	236.11

Эх сурвалж: АМГТХЭГ

Шижир Алт Компани

Монголросцветмет нь монголын томоохон алтны уурхайнуудын нэг болох Шижир Алт компанийн гол хувьцаа эзэмшигч нь юм. Шижир Алт компани нь байгуулагдсан цагаасаа хойш үйлдвэрлэлээ тогтвортой явуулж байгаа тэргүүлэх алтны компаниудын нэг юм. Компани нь 1994 онд байгуулагдсан.

Компани нь 3 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд эдгээр нь Монголросцветмет нэгдэл (51%), Зарубежцветмет Оросын компани (24%) болон Эрдмин компанийн тодорхой хувьцаа эзэмшигч MICO Holding (25%) юм. 2004 оны эцсийн байдлаар Шижир Алт Компани нь өөрийн 50 хувийн ашгаа Монголросцветметэд өгсөн байна.

Шижир Алт компани нь үйл ажиллагаагаа Төв аймгийн нутаг дахь Заамарын алтны орд дээр явуулдаг. Заамарын ордыг 1995 оноос эхлэн ашиглаж ирсэн бөгөөд энэ хугацаанд нийт 12.6 тонн алт олборлосон. Уурхайн ажил хоёр шанаган шугамтай драгаар жилийн турш тасралтгүй явагддаг. Одоогийн байгаа ордын нөөц нь 6.16 тонн алт бөгөөд энэ нь 2011 он хүртэл уурхайг ашиглах боломжтой гэсэн үг юм.

Хүснэгт 15: Шижир алт компанийн алт олборлолт

	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Алт олборлолт, кг	1,364.7	1,274.8	1,186.0	1,453.43	1,234.1	1,274.3	1,210.6

Эх сурвалж: АМГТХЭГ

Шижир Алт компани нь геологийн хайгуулын ажлыг мөн эрчимтэй явуулж байна. 2004 онд компани нь Монголын баруун хэсэгт 700 гаруй мянган ам.долларын үнэтэй хайгуулын ажлыг хийгээд байна.

Тулгарч буй бэрхшээлүүд

Компанийн гол бэрхшээлүүд нь түрүүчийн удирдлагын систем муу байснаас үүдэлтэй. Өнөөдрийн байдлаар дундаж хэмжээний үйлдвэрлэлийг тогтвортой явуулахад шаардлагатай байгаа ажлын капитал дутагдаж, санхүүгийн хүндрэлүүдтэй компани нь тулгарсаар байна.

Хувьчлал болон компанийн гол худалдан авагч байсан Орос улсын Полевской Криолитын үйлдвэр нь дампуурч Монголросцветмет нэгдлээс 2003 онд худалдан авсан бүтээгдэхүүний 4 сая гаруй ам.долларын төлбөрийг төлөөгүйгээс санхүүгийн хүндрэлүүд үүссэн байна. Энэхүү хүндрэлээс гарахын тулд тус нэгдэл нь банкнаас 1 сая гаруй ам.долларын зээлийг авсан байна. Энэхүү мөнгөн хөрөнгө нь зориулалт бусаар хэрэглэгдэж, улмаар компанийн санхүүгийн байдлыг улам хүндрүүлсэн юм[8].

Өнөөгийн байдлаар жоншны үйлдвэрлэл нь зөвхөн зардлаа нөхөх хэмжээнд явж байна. Жоншны үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж нь ихэнхдээ хуучирсан бөгөөд шинэчлэл хийх шаардлагатай байгаа. Компанийн өрсөлдөх чадварыг ойрын ирээдүйд дээшлүүлэхэд их хэмжээний мөнгө шаардагдаж байна.

Төлөвлөгөө

Монголросцветмет нэгдэл нь 2005-2015 онуудад нэгдлийг хөгжүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөртэй байна. Энэхүү хөтөлбөрөөр нэгдлийн дунд ба удаан хугацааны зорилтуудыг тодорхойлсон. Энэ боловсруулсан бичиг баримт дээр үндэслэхэд нэгдлийн алт олборлолт багасах бөгөөд 2011 он гэхэд алт олборлолтын хэмжээ өнөөгийнхөөсөө хоёр дахин буурах юм байна.

Алтны үйлдвэрлэлээс гадна Монголросцветмет нь онолын хувьд нэгдлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асар их боломжтой гэж үзэж байгаа бусад үнэт металлыг олборлох хэд хэдэн төсөлтэй байгаа юм байна. Үүний нэг нь Асгатын орд бөгөөд энэ нь Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дээр Улаанбаатараас баруун зүгт 2,000 км-ийн зайд байрладаг. Уг ордыг тооцоолсноор нөөц нь 2,640 тонн мөнгөний агуулгатай, 8,200 мянган тонн хүдэр юм. Ордын металлургийн туршилтуудыг хэд хэдэн удаа АНУ-ын Dawson болон Орос улсын Gintsvetmet, Maria-Trade зэрэг компаниудаар хийлгүүлсэн байна. Мөн ордыг ашиглах тухай урьдчилсан судалгааны ажлуудыг Туркийн ETIBank, Канадын Dentonia болон Орос улсын Гидроцветмет, Сибгидрозолото зэрэг байгууллагууд хийжээ. Асгатын ордыг ашиглах төсөл нь харьцангуй сонирхолтой төсөл боловч үүнийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн үзүүлэлтүүд хүндрэл учруулж болзошгүй бөгөөд үүнд, үндсэн зах зээлээс хол

[8] Төрийн Өмчийн Хорооны үзэж байгаагаар авсан зээлийг нэгдлийн түрүүчийн Ерөнхий захирал нь зориулалт бусаар ашигласан бололтой

байршилтай, дэд бүтэц хөгжөөгүй, ордын байршил нь өндөр уулын дунд байдаг тул олборлолт явуулахад бэрхшээлтэй зэрэг болно. Дэлхийн зах зээл дээр мөнгө металлын үнэ ашигтай ажиллагаанд явуулах боломжтой хэмжээнд өсөх тохиолдолд Асгатын ордыг эдийн засгийн хувьд олборлох боломжтой болох юм.

3.5 Алтан Дорнод Монгол

Алтан Дорнод Монгол нь Монгол улсад олборлолт эрхэлж буй удаах томоохон алт олборлогч компани юм. Жилдээ бараг 4 тонн алт олборлож байгаагаараа зөвхөн Бороо Голд компанийн дараа ордог юм. Тус компанийг 1997 онд 100 хувийн ОХУ-ын хөрөнгө оруулалттай монголын аж ахуйн нэгж хэлбэрээр байгуулж байсан болно. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь алт олборлолт болно.

Үйлдвэрлэл

Монгол улсын төв хэсэгт орших 17 ордыг алт олборлох зорилгоор АДМ эзэмшиж байна. Тус компанийн Гүйцэтгэх захирлын хэлсэнчлэн 2004 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнд эдгээр ордууд ойролцоогоор 24.5 тонн алтны нөөцтэй гэж тогтоожээ. Өнөөгийн хүчин чадлаараа компани нь ажиллах тохиолдолд ордуудыг 7 жилийн туршид ашиглаж алт олборлох боломжтой гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар Алтан Дорнод Монгол компани нь Монгол нутгийн төв хэсэгт орших 7 ордуудыг ажиллуулж байна. Тус компанийн үндсэн дөрвөн ордууд нь Шижир алт ба Монполимет компаниудын уурхайн зэргэлдээ Заамар сумын нутагт оршдог[9]. 2004 оны эцсээр Алтан Дорнод Монгол нь 3,899.78 кг алт олборлосон байна.

Хүснэгт 16: Алтан Дорнод Монгол компанийн алт олборлолтын хэмжээ

	1999	2000	2001	2002	2003	2004
Алт олборлолт, кг	4.3	1,252.4	2,611.4	2,914.1	3,067.29	3,899.78

Эх сурвалж: АМГТХЭГ

Тулгамдсан асуудлууд

АДМ-ийн ордын дэргэд газарт үй олноороо гар аргаар алт ухагч (нинжа) нарын ажиллаж үйл ажиллагаанд нь саад болж буй талаар тус компанийн Гүйцэтгэх захирал дурьдаж байлаа. Төв, орон нутгийн удирдлагуудтай буруу зөрүү ойлголцоноос болж нинжа нар АДМ компанийн мэдлийн нутагт алт ухаж байна гэлээ. Энэ оны дөрөв дүгээр сараас эхлэн энэ асуудал гарч ирсэн бөгөөд төв, орон нутгийн хойрго үйл ажиллагааны улмаас наймдугаар сар хүртэл асуудлыг шийдэж өгөөгүй гэв. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд АДМ компани нь Монгол улсад суугаа Оросын Холбооны Улсын Элчин сайдын яаманд хандаж Оросын компанийн эрх ашгийг хамгаалах хүсэлтийг Оросын Засгийн газарт хүсэлт тавьсны үндсэн дээр нинжатай холбоотой асуудлыг шийдвэрлэж өгсөн байна. Компанийн эзэмших ордын дэргэдэх нутагт нинжа нарын хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас тус компанид 500 кг гаруй алтны хэмжээтэй тэнцэх хохирол учирсан гэж компанийн удирдлага үзжээ.

[9] Алтан Дорнод, Шижир Алт болон Монполимет компаниуд нь үндсэндээ нэг том шороон ордыг ашигладаг болно. Эдгээр компаниуд нь драгийн технологийн аргаар алт олборлож буй компаниуд юм.

Төлөвлөгөө

Монголын алтны бусад компаниудтай харьцуулбал АДМ компани нь холыг харсан Монголын алт олборлодог компаниудын дунд байхгүй хэтийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Саяхан АДМ компани нь үлдэж буй арван жилийн хугацаанд баримтлан ажиллах хөгжлийн стратеги, зорилтуудаа тодорхойлсон “Бизнес төлөвлөгөө”-г боловсруулжээ.

АДМ компанийн дунд хугацааны үндсэн чиглэлийн нэг бол үндсэн ордуудыг хөгжүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор геологийн хайгуулын хөтөлбөрийг идэвхжүүлэх гэж тусгажээ. Энэхүү төлөвлөгөөний дагуу Торонто дахь үнэт цаасны бирж дээр 12 сая америк долларын энгийн хувьцааг гаргахаар төлөвлөж байна. Үүгээр компанийн олон улсын санхүүгийн зах зээл дэх нэр хүндийг нэмэгдүүлж, ирээдүйн хайгуулын болон бусад хөтөлбөрийн урт хугацааны санхүүгийн эх үүсвэрийг олох боломжийг мөн хайхад чиглэсэн болно. Алт олборлох үйлдвэрлэлийн хувьд АДМ компани нь үндсэн ордын уурхай болох магадлал ихтэй сайтар судлагдсан цөөн хэдэн төслүүдтэй. Тэгэхдээ эдгээр төслүүдэд цаашид ч нэмэлт өрөмдлөгийн ажил шаардлагатай байна.

Компанийн ойрын ирээдүйн хоёр дахь төлөвлөгөө нь Тайшетээс (ОХУ) Находка (ОХУ) руу барих газрын тос дамжуулах хоолойг барих ажилд оролцоход оршино. Тайшет Находкагийн хооронд барих газрын тос дамжуулах хоолойг барих ажил нь алс дорнод бүс болон Япон, Өмнөд Солонгос улс, Хятад улсын хойд хэсгүүдийг эрчим хүчний нөөцөөр хангах ОХУ-ын Засгийн газрын эрчим хүчний төсөл мөн. Хэдийгээр энэ нь Засгийн газраас санхүүжигдэх хөтөлбөр ч Япон улсын нилээд хэдэн хөрөнгө оруулагчид дамжуулах хоолойг барих ажилд оролцох бололтой. ОХУ-ын ГазПром компани нь газрын тос болон байгалийн хий үйлдвэрлэгч тэргүүлэх компанийн хувьд дамжуулах хоолойг барих тендерт ялж АДМ компанитай хөрс хуулах ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Шаардлагатай урьдчилсан тооцоо, судалгаа хийгдэж дууссан бөгөөд дамжуулах хоолойг барих ажлыг 2006 онд эхлүүлэхээр төлөвлөж байна.

АДМ компани нь Сүхбаатар аймагт газрын тос боловсруулах үйлдвэр байгуулснаар Монгол улсын газрын тосны үйлдвэрлэл рүү үйл ажиллагаагаа тэлэх төлөвлөгөөгөө дээр дурьдсан хөтөлбөрийн нэг хэсэг болгон ажиллах төлөвлөгөөтэй байна. Уг төлөвлөгөөний дагуу жилдээ 326 сая тонн газрын тос үйлдвэрлэх зорилгоор ОХУ-аас түүхий боловсруулаагүй тосыг импортоор оруулж ирнэ. Бүтээгдэхүүний ихэнх хувийг орон нутгийн зах зээл дээр борлуулах бөгөөд илүү гарсныг нь Хятад улс руу экспортод гаргана. Газрын тос боловсруулах үйлдвэрийг барих ажлыг Востокнефтегаз (ОХУ) компанитай хамтран гүйцэтгэнэ. АДМ компани нь боловсруулах үйлдвэрийн банкны тооцоо, судалгааг хийж ОХУ-ын ВнешЭкономБанкинд гаргаж өгсөн байна. Энэ тооцооны нөхцөлөөр үйлдвэрийг байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг долоон жилийн хугацаанд буцааж төлөхөөр гарчээ.

Нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар ямар нэгэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа эсэхийг тодруулах асуултад алтны хувьд нэмүү өртөг үнэ нэмэгдүүлснээр олох ашиг нь бага гэж харуулсан билээ. Иймд металлын өвөрмөц шинж чанараас хамааран бага ашиг гарах бизнес руу үйл ажиллагаагаа тэлэхгүйгээр компанийн үйл ажиллагааг газрын тосны бизнес рүү чиглүүлж оруулах нь илүү их унацтай байх болно.

Ерөнхийдөө АДМ-ын ажлын төлөвлөгөөнүүд нь санхүүгийн болон өргөн хэрэглээний бараа таваарын томоохон зах зээлд нэвтрэх орцтой холбоотой компанийн өнөөгийн боломж, илэрхий давуу талууд дээр тулгуурласан байна.

3.6 Монполимет Компани

Монполимет ХХК нь Монгол улсын үндэсний алт олборлогч томоохон компаниудын нэг билээ. Тус компани нь Төв аймгийн Тосон суманд орших хоёр шороон ордын уурхайг ажиллуулдаг. Монполимет компанийн нэг уурхай нь сайн мэдэх Тосонгийн гольдролын шороон орд юм. Ордыг 2001 оноос эхлэн Тосон алт Монгол-Японы хамтарсан үйлдвэр ажиллуулж эхэлсэн бөгөөд одоогоор Монполимет компани нь тус үйлдвэрийн 51 хувийг эзэмшиж, үлдсэн хувийг нь Японы Иточу Худалдааны Монгол дахь Төлөөлөгчийн газарт ажиллаж байсан Япон улсын хөрөнгө оруулагч эзэмшдэг байна.

Алтны үйлдвэрлэл

Монполимет компани нь Тосонгийн дэнж ордыг албан ёсоор бие даан ашигладаг. Ордыг уламжлалт хөрс хуулж энгийн угаах аргаар ашигладаг. Тосонгийн дэнжийн ордыг ойролцоогоор 3.3 тонн нөөцтэй гэж тогтоожээ. Ордыг өнөөгийн хүчин чадлаар 13 жил олборлож ажиллана гэж үздэг байна. Тосонгийн дэнжийн уурхайгаас жилдээ 200 кг илүүгүй алтыг олборлодог байна.

Тосон Алт компани

Хоёр дахь орд болох Тосонгийн гольдролыг 80-аад оны сүүлээр нилээд ашигласан байна. Хэдийгээр ордыг нилээд эрт нээсэн ч компанийн санхүүгийн нөөц хомс байдлаас шалтгаалан ордыг бүрэн ашиглаж чадахгүй байжээ.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд Тосон гольдролын ордыг хэд хэдэн Засгийн газрууд өөрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглажээ. Сүүлийн гурван Засгийн газар өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Тосонгийн гольдролын ордыг ашиглах зорилгыг тэргүүний зорилго болгон дэвшүүлж байжээ. Хоосон лоозонгоос өөр ямар нэгэн дэмжлэгийг Монполимет компанид Засгийн газраас үзүүлээгүй байна. Хувийн хөрөнгө оруулалтын ачаар ордыг 2001 онд ашиглаж эхэлсэн байна.

Тосонгийн гольдрол нь Монполимет, Шижир Алт, Алтан Дорнод Монгол зэрэг гурван компанийн эзэмшдэг алтны зурвастай талбайн газрын нэг хэсэгт оршдог. Хэрэв Монполимет компанийн эзэмшлийн талбайн урт нь 15-аас 17 км бол өргөн нь 3-5 км-ийн хооронд байдаг байна. Тосонгийн гольдролын ордыг 13.5 нөөц алттай гэж үздэг юм байна. Энэ ордыг өнөөгийн хүчин чадлаар 15 жил ашиглах тооцоотой юм байна. Дагалдах орд нээх нь нөөцөө нэмэгдүүлэх өндөр боломжтой гэж үздэг юм байна. Жилийн туршид хоёр драгаар Тосон ордыг ажиллуулжээ. Эхний драгыг 2004 онд ажиллуулж эхэлсэн бол хоёр дахь драгийг угсарч 2005 оны 5 дугаар сард ажилд оруулсан байна. Хоёр драг нь өнөөгийн хүчин чадлаар жилдээ 750-950 кг алт олборлох боломжтой.

Хүснэгт 17: Алт олборлолт (Нийлбэр дүнгээр)

	1999	2000	2001	2002	2003	2004
Алт олборлолт, кг	265.78	269.76	280.085	151.88	438.8	531.3

Эх сурвалж: АМГТХЭГ

Төлөвлөгөө

Үндсэн хөрөнгийн өндөр өртөг зардал нь компанийн өмнө тулгарч буй үндсэн асуудал болоод байна. Хэдийгээр Монполимет компани нь Японы хувийн хөрөнгө оруулалттай эзэмшигчийн хөрөнгөд хөрөнгө оруулалтаар Тосонгийн ордыг түшиглэн хамтарсан үйлдвэр байгуулсан ч бодит байдал дээр энэ нь тийм хялбар асуудал биш болоод байна. Тосон алт компани нь жилийн эцэст ногдол ашиг тараахаас гадна хөрөнгө оруулалтын үндсэн хөрөнгөд хүү төлдөг учир хөрөнгө оруулалт нь мөнгөн хөрөнгө оруулалт уу эсхүл эзэмшигчийн хөрөнгө оруулалт уу гэсэн бүрхэг асуудал гарч иржээ. Ямар ч гэсэн энэ хөрөнгө оруулалт нь их өндөр өртөг зардалтай тул компанийн үйлдвэрлэлийн явцад саад тотгор болж байдаг байна. Иймд тус компани нь энэ өндөр өртөг зардалтай хөрөнгө оруулалтыг зах зээлийн өрсөлдөөнт хүүтэй урт хугацааны зээлээр сольж, өөрийгөө санхүүжүүлж, хөрөнгөө эрүүл саруул болгох төлөвлөгөөтэй байна.

3.7 Эрдэс Компани

Эрдэс бол алт олборлогч тэргүүлэх компаниудын дунд хамгийн бага нь билээ. Тэгсэн ч уг компани нь Монгол улсын дунд хэмжээний компанийн түгээмэл жишээ болгохын хувьд энэ тайланд оруулсан болно.

Эрдэс компанийг 1992 онд Эрдэс баялгийн шинжлэх ухаан, технологийн төвөөр байгуулсан юм. Тэгэхдээ Төв нь санхүүгийн бэрхшээлтэй тулгарсны улмаас алт олборлох үйл ажиллагааг эрхлүүлэх зорилгоор 1993 оны эцсээр Эрдэс-алт жижиг үйлдвэр болгон өөрчилжээ. Эрдэс компанийн алт олборлох түүх нь 1993 оноос Төв аймгийн Заамар нутагт Баянгол алтны үндсэн уурхайг ажиллуулж эхэлснээр түүхэн хуудсаа нээжээ. Тус үйлдвэр нь уурхайг ашиглах таатай үйл ажиллагааны ачаар 1993 оноос 2000 оны хооронд тогтвортой өсөж иржээ. 2000 онд үйлдвэрийг хямдхан хэлбэрээр хувьчилж, Эрдэс Холдинг компани болгон өөрчлөн байгуулсан байна.

Үйлдвэрлэл

Өнөөгийн байдлаар Эрдэс компани нь Улаанбаатар хотоос 230 км хойд зүгт Дархан Уул, Сэлэнгэ аймагт орших хоёр үндсэн уурхайг ашигладаг байна. Тодруулбал,

- Дархан уул аймгийн Шарын гол сумын нутагт орших Их шарын гол үндсэн орд, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Буян хар морьт үндсэн орд зэрэг болно.

Тулгамдсан асуудлууд

Компанийн өнөөгийн олборлож байгаа ордын нөөц нь дуусгавар болж, үлдэж буй нөөц нь үйлдвэрлэлийг удаан хугацаагаар явуулахад ашиггүй болж байна.

Ордын үлдэж байгаа алтны нөөц нь ойролцоогоор 900 кг бөгөөд үүнийг уурхай ажиллуулах нэг л улиралд олборлоод авна. Эрдэс компанийн ирээдүйн зураглалыг гаргахад алтны нөөц дуусаж байгаа, сайн судалсан орд байхгүй, өртөг өндөртэй хайгуулын ажил хийх шаардлагатай зэрэг үндсэн хүчин зүйлсүүдийг харгалзан үзэх нь зүйтэй. Түүнчлэн, компанийн их хэмжээний төлөгдөж дуусаагүй байгаа өр, үүнтэй уялдсан компанийн санхүүгийн ядмаг байдал асуудлыг улам төвөгтэй болгож байна.

Өнөөгийн байдлаар тус компани нь байгаа өр төлбөрөө нэгтгэх, богино хугацаатай өртөг өндөртэй хөрөнгө оруулалтыг урт хугацаатай зээлээр дахин санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хайж байна. Геологийн хайгуулын ажлыг санхүүжүүлэх нөөцийг олж, компанийн урт хугацааны алтны үйлдвэрлэлийг хангаж чадахуйц хангалттай алтны нөөцтэй ордыг хөгжүүлснээр л алт олборлогч компанийн хувьд Эрдэс компанийн ирээдүйг баталгаажуулж болох билээ.

3.8 Гянт болд үйлдвэрлэгчид

MonWolfram нь Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй цөөн тооны гянт болд олборлогч компанийн нэг юм. Тус компани нь Цагаан Даваану гянт болд гүний уурхайг ажиллуулдаг. Гянт болдын баяжмалыг үйлдвэрлэх бага оврын хүдэр боловсруулах үйлдвэр, тоосгоны үйлдвэр гэх зэрэг барилга байгууламжаас бүрдсэн энэхүү жижиг хэмжээний уул уурхайн цогцолборыг анх 1989 онд Унгарын Засгийн газраас олгосон техникийн туслалцааны үндсэн дээр байгуулж байсан. Тус уурхай нь Улаанбаатар хотоос 76 км-т буюу Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт байрладаг.

Үйлдвэрлэл

Цагаан Даваа ордын нийт батлагдсан нөөц нь 165.4 мянган тонн хүдэр буюу 2,7 мянган тонн металл юм. Тус үйлдвэр нь жилдээ наад зах нь 35.0 мянган тонн гянт болдын баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай. Өнөөгийн байдлаар тус үйлдвэр нь жилдээ ойролцоогоор 30.0 мянган тонн гянт болдын баяжмал үйлдвэрлэж байгаа. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Хойд Америкийн зах зээл дээр борлуулдаг. Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд саад болж буй гол зүйл нь эргэлтийн хөрөнгө хомс байгаатай холбоотой юм.

Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор өнгөрсөн жилд тус компани нь өөрсдийн ашиглаж буй гол тоног төхөөрөмжүүдээ шинэчилж чадсан.

Хүснэгт 18: Гянт болдын үйлдвэрлэл

	2003	2004	2005
Гянт болдын баяжмал, 000’ тн	-	31.47	50.0

Эх сурвалж: АМГТХЭГ

Төлөвлөгөө

Өнөөгийн байдлаар тус компани нь эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хайж байна. Компанийн төлөвлөгөөний дагуу ордын дэргэдэх талбайд хайгуулын ажлыг нэмэгдүүлэхээр байгаа. Учир нь дагалдах орд нээх замаар ордын нөөцийг нэмэгдүүлэх магадлал өндөр юм. Хайгуул хийх зорилгоор тус компани нь 142 гектар газартай бөгөөд энэ нь гол төлөв ашиглаж буй ордын дэргэдэх орчинд байрладаг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГОВЬ БОЛОН ЗҮҮН БҮСИЙН ИРЭЭДҮЙТЭЙ ШИНЭ ОРД

4.1 Үндсэн гол ордыг хөгжүүлэх бодлого

Монгол улс тус бүс нутагт ашигт малтмалын гол үйлдвэрлэгч болох асар их боломжтой. Тус улсад зэс, молибден, алт болон бусад үндсэн металлын нилээд их нөөцтэй хэд хэдэн сонирхолтой орд байдаг. Шаардлагатай дэд бүтэц, санхүүгийн зохих нөөц байхгүйгээс эдгээрийн ихэнх нь өнөөг хүртэл ашиглагддаггүй байсан. 2004 оны жилийн эцсийн байдлаар АМХЭГ-т 6,000 орд ба 80 гаруй төрлийн ашигт малтмалын янз бүрийн илрэл бүртгэгдсэн байсан. Эдийн засгийн хувьд хамгийн чухал ач холбогдолтой нь үндсэн металл, алт болон хайлуур жонш юм. 2004 оны жилийн эцсийн байдлаар гаргасан Засгийн газрын мэдээгээр тус улсын ашигт малтмалын батлагдсан нөөцийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 18: Зарим ашигт малтмалын нийт батлагдсан нөөц

	Хэмжих нэгж	2004 оны жилийн эцсийн байдлаар
Алт		
үндсэн орд	Метрийн тонн	64.7
Шороон орд	Метрийн тонн	62.3
Мөнгө	Мянган метрийн тонн	8.76
Зэс	Сая метрийн тонн	6.92
Төмрийн хүдэр	Сая метрийн тонн	427.1
Вольфрам	Мянган метрийн тонн	63.67
Хар тугалга	Сая метрийн тонн	1.92
Цайр	Сая метрийн тонн	1.56
Уран	Мянган метрийн тонн	64.0
Нүүрс	Тэрбум метрийн тонн	3.54
Хайлуур жонш	Сая метрийн тонн	14.24

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар

Хар төмөрлөг болон өнгөт металлын хувьд дор дурьдсан ордуудыг гол ач холбогдолтой гэж Засгийн газар үзэж байна. Үүнд:

- Оюу Толгойн зэс, молибдены орд,
- Цагаан Суваргын зэсийн орд,
- Гацууртын алтны үндсэн орд,
- Тавтын алтны орд,
- Цавын полиметаллын орд,
- Улааны полиметаллын орд

Эдгээр ордыг ашиглалтад оруулах асуудлыг Засгийн газрын баримт бичгүүдэд тусгасан[10]. Үүнээс гадна энэхүү баримт бичигт эдгээр ордын ашигт малтмалын арилжааны үйлдвэрлэл эхлэх хугацааг мөн тодорхой заасан байгаа. Харамсалтай нь ордуудыг ашиглалтад оруулах талаар дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зааж өгөөгүй байна.

[10] Монгол Улсын геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол

Засгийн газрын баримт бичгүүдийг судалж үзэхэд, мөн эдгээр орд дээр уурхай ажиллуулж буй компаниудтай уулзаж ярилцахад нэгэн сонин зүйл ажиглагдаж байгаа нь Засгийн газрын ямар ч оролцоогүйгээр хувийн компаниудын хөрөнгөөр саяхан ашиглалтад оруулсан эдгээр ордыг дээрх баримт бичигт Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүн гэж тайлбарласан байна[11]. Эдгээрээс үзэхэд Засгийн газрын өнөөгийн үйл ажиллагааны зарчим нь зорилт тавих, биелэгдсэн хэдэн зорилтыг Засгийн газрын арга хэмжээний үр дүн гэж танилцуулах явдал болоод байна. Харамсалтай нь Засгийн газрын баримт бичгүүдэд арилжааны үйлдвэрлэлийг эхлэх жил, хугацааны тооцооноос гадна дээрх ордуудыг ашиглалтад оруулахад бодит дэмжлэг үзүүлэх талаарх ямар ч өөр арга хэмжээ тусгаж тодорхойлоогүй байна. Мөн дээр дурьдсан ирээдүйтэй ордуудыг хөгжүүлэх бодлого ч гэсэн ялгаагүй байна. Засгийн газрын гол оролцоо нь зөвхөн уул уурхайн салбарт 2 сая ам.доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж буй хөрөнгө оруулагчтай “Тогтвортой байдлын тухай гэрээ”-г байгуулах асуудлаар л өндөрлөж байна.

4.2 Зарим ирээдүйтэй алт, зэсийн орд

Оюу Толгой

Оюу Толгой нь Монголын өмнөд хэсэгт оршдог хамгийн чухал ач холбогдолтой зэс, молибдены орд бөгөөд цаашид түүнийг олборлосноор дэлхийн зэрэгтэй зэс, алтны уурхайг байгуулах боломж байна. Оюу Толгойг ашигт малтмалын эрэл хайгуул хийдэг Канадын Айвенхоу Майнз компани 100% эзэмшдэг. AMEC America Limited компаниас бэлтгэсэн хамгийн сүүлийн үеийн бие даасан тооцоогоор Оюу Толгойн орд бол 1.15 тэрбум тонн 1.3%-ийн агуулгатай зэс болон 0.47 гр/тонн агуулгатай алтны тооцсон болон таамагласан нөөцийг агуулдаг[12] гэжээ.

Айвенхоу Майнз компанийн тэмдэглэснээр тус компани нь Монголын өмнөд хэсгүүдэд орших зэс, алтны ордуудыг хамтран олборлох зорилгоор Mitsui & Co. Ltd.-тай стратегийн холбоо байгуулаад байгаа. Энэ холбоо нь Оюу Толгой төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах дэд бүтцийг байгуулах асуудалд нэн тэргүүнд анхаарлаа хандуулна. Айвенхоу Майнз компанийн тооцоолсноор арилжааны үйлдвэрлэлийг 2008 оны эхээр эхлүүлэх төлөвлөгөөтэй байна. Гэхдээ эдгээр тооцоо нь Монгол Улсын Засгийн газраас үзүүлэх дэмжлэгээс нилээд их хамаарна. Ордыг ашиглах үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Айвенхоу Майнз нь Монгол Улсын Засгийн газартай “Тогтвортой байдлын тухай гэрээ”-г байгуулах асуудлыг хэлэлцэж байна. Гэхдээ Монгол Улсын Засгийн газар нь ордын ашиглалтаас гарах мэдрэгдэхүйц эдийн засгийн үр ашгийг үл харгалзан Оюу Толгойн ордын олборлолтын талаар ямар нэгэн эцсийн шийдвэрийг гаргах асуудалд дурамжхан хандаж байна. Айвенхоу Майнзын шинжээчдийн үзэж байгаагаар Оюу Толгойн ордын олборлолт нь Монгол Улсын эдийн засагт дараах нөлөөг үзүүлнэ гэжээ. Үүнд:

1. Бодит ДНБ 34.3%-иар өснө,
2. Хөдөлмөр эрхлэлт 117 мянгаар өснө,
3. Засгийн газрын үйл ажиллагааны баланс 7.9 тэрбум ам.доллараар нэмэгдэнэ,
4. Экспорт 54 тэрбум ам. доллараар нэмэгдэнэ[13].

[11] 2006-2008 оны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, 46-р хуудас
[12] Оюу Толгой Төсөл: Нэгдсэн Төлөвлөгөө
[13] Оюу Толгой Төсөл: Нэгдсэн Төлөвлөгөө

“Тогтвортой байдлын тухай гэрээ”-г байгуулах асуудлыг хойшлуулах гол шалтгаан нь эрх баригч улс төрийн хүчнүүд Оюу Толгойн орд шиг (сүүлийн сонгуулийн кампанит ажлын үеэр Оюу Толгойг олон нийтийн сурталчилгааны зорилгоор нилээд эрчимтэй ашигласан тул) эмзэг асуудлуудаар ямар нэгэн шийдвэр гаргах хүсэл эрмэлзэлгүй байгаатай холбоотой юм. Айвенхоу Майнз гэрээг эцэслэн тохиролцож 2005 оны сүүлээр түүнд гарын үсэг зурна гэж найдаж байгаа боловч мэдээлэл сайтай эх үүсвэрээс өгсөн мэдээгээр бол гэрээ байгуулах асуудлыг дахин хойшлуулах магадлалтай байна.

“Тогтвортой байдлын тухай гэрээ”-г байгуулах асуудлаас гадна Оюу Толгойн ордыг олборлож уурхай байгуулахын тулд ордын орчин тойронд төмөр зам, тээврийн сүлжээ зэрэг сайн дэд бүтцийг бий болгож, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болох шаардлагатай байна. Говийн бүсэд ашигт малтмалын ордуудыг ашиглаж эхлэхийн тулд эрчим хүчний хангамжийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй байгаа бөгөөд энэ асуудлыг тус бүсэд ашиглагдаж буй Таван Толгойн том нүүрсний орд дээр тулгуурлан эсвэл Оюу Толгойд 110/220 МВ-ын цахилгаан станц шинээр барих замаар шийдвэрлэж болох юм. Ингэхийн тулд өндөр хүчдэлийн шугам татаж, төмөр зам барих шаардлагатай болно.

Гацууртын орд

Гацууртын орд нь сүүлийн үед илрүүлсэн хамгийн том алтны ордуудын тоонд ордог. Гацууртын ордыг үндэслэн уурхай байгуулах нилээд их боломж байна. Энэ орд Улаанбаатараас зүүн хойшоо 120 километрийн зайд Төв аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог. Өнөөдрийн байдлаар энэ ордыг алтны эрэл хайгуул, олборлолт хийдэг Канад улсад бүртгэгдсэн Сентерра Голд (хуучнаар Камеко) алтны компани эзэмшдэг.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд Гацууртын алтны ордод нилээд их хэмжээний өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн, мөн түүнчлэн техник, эдийн засгийн тооцооны өмнөх төмөрлөгийн туршилтуудыг явуулсан. Эрэл хайгуулын урьдчилсан үр дүнгээс үзэхэд Гацууртын ордын алтны нийт нөөц нь 39.5 тонноор хэмжигдэж байна. Сентерра Голд саяхан Гацууртын ордыг ашиглах талаар бие даасан техник, эдийн засгийн судалгаа хийхээр санаачлаад байна.

Монгол Газар компанийн төслүүд

Монгол Газар компани нь Архангай аймагт оршдог Харгуйтын шороон алтны орд, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр байрладаг Олон Овоотын алтны үндсэн орд зэрэг хэд хэдэн ирээдүйтэй төсөлтэй юм.
Харгуйтын төслийг анх Иточу Корпораци 12 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж санхүүжүүлж эхэлжээ. Иточу ихэвчлэн хүнд тоног, төхөөрөмжийн нийлүүлэлтийг санхүүжүүлсэн. Тус орд зарим хэсгээрээ байнгын хөлдөлттэй, шавартай газарт байрладгаас алт угаахад хүндрэлтэй байх зэрэг гол хүндрэлүүд гардаг. Алтны ширхэгт нь бага хэмжээтэй учир угаах аргаар алтыг салгаж олборлоход алтны гарц дунджаар 75%-тай тэнцдэг буюу харьцангуй доогуур байдаг. Монгол Газар нь үлдэгдлээс нарийн ширхэгтэй алт гаргах технологийг туршиж байгаа.

Монгол Газар компани мөн Олон Овоотын алтны ордыг эзэмшдэг. Тус орд нь Улаанбаатараас урагшаа 550 километрийн зайд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт оршдог. Олон Овоотын ордын алтны батлагдсан нөөц нь 18 тонн гэж тооцогддог. Олон Овоотын орд дээр цаашид эрэл хайгуул хийхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр байхгүй учраас Монгол Газар компани саяхан Канадын Юниортай урьдчилсан

тохиролцооны бичигт гарын үсэг зурсан. Урьдчилсан тохиролцооны дагуу Канадын Юниор Олон Овоотын ордын эзэмшлийн 22%-ийг авсан.

Тавтын орд

Тавтын орд нь алт-мөнгө-зэсийн агуулгатай кварцын судал агуулсан үндсэн ордоос бүрддэг. Тус орд Улаанбаатар хотоос 540 километрийн зайд Булган аймгийн нутаг дэвсгэрт оршдог. Тавтын орд нь Монголын хойд хэсэгт ажиллаж буй алтны үндсэн ордыг түшиглэсэн туршилтын уурхай бөгөөд M & Diamond Ltd. Монгол-Оросын хамтарсан компанийн эзэмшилд байдаг. Тус компани 1996 онд байгуулагдсанаас хойш ОХУ-ын Буриад Улстай хил залгаа Булган аймгийн нутаг дэвсгэрт орших Тавтын орчимд эрэл хайгуулын лиценз авсан. Компанийн гол зорилго нь Тавтын алтны үндсэн ордыг ашиглахад оршино. Анх Тавтын алтны ордыг 1986-1988 онд Оросын геологичид нээж, 130 тонн алтны хүдэр, 370 тонн мөнгө болон нилээд их хэмжээний зэсийн нөөцтэй гэж тооцоолсон.

Сүүлийн хэдэн жилүүдэд M & Diamond нилээд их хэмжээний өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, 5.6 тонн алт, 25 тонн мөнгө болон нилээд их зэсийн нөөцийг баталсан. Өрөмдлөгийн үр дүнд алтны агуулгыг 7.8 гр/т, мөнгө 45 гр/т ба зэс 1.3% гэж тогтоожээ.

M & Diamond компани нь алтны үндсэн ордын уурхайг байгуулж, өдөрт 100 тонн хүчин чадалтай алтны туршилтын үйлдвэрийг өөрийн нөөцийг түшиглэн барихаар төлөвлөж байгаа.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД ОРНУУДЫН МЕТАЛЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 7 гаруй хувьтай буюу дэлхийд хамгийн өндөр байсан. Өнөөдөр тус улсын ДНБ-ний өсөлт бараг 9 хувиас дээгүүр байна. 2004 оны жилийн эцсийн байдлаар бараг 1.5 триллион ам.доллартай тэнцэх ДНБ-тэй байсан БНХАУ дэлхийн хамгийн том эдийн засагтай орнуудын дунд 7 дугаар байранд орсон байна. Өнөөдөр БНХАУ дэлхийн ДНБ-ний ойролцоогоор 11 хувийг эзэлж байна.

Ойрын ирээдүйд БНХАУ-ын эдийн засаг дэлхийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэнэ. Эрчимтэй өсөж буй эдийн засагтай БНХАУ дэлхийн зэсийн хэрэглээний 20 гаруй хувь, газрын тосны хэрэглээний 10 хувийг тус тус эзэлж байна. Эрчим хүч болон ашигт малтмалын нөөцөөс хамаарах явдал нь чухал шийдвэрлэх хүчин зүйл болж байгаагаас гадна БНХАУ-ын эдийн засгийн ирээдүйн хөгжил болон БНХАУ-д ашигт малтмалын нөөцийг нийлүүлэх боломжтой бусад хил залгаа улс орнуудын эдийн засагт чухал нөлөө үзүүлэх болно.

5.1 БНХАУ-ын өнгөт болон зарим үндсэн металлын эрэлт хэрэгцээ

Зэсийн үйлдвэр

БНХАУ-ын эдийн засаг сүүлийн хэдэн жилүүдэд маш эрчимтэй өсөж ирсэн. Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг даган зэсийн эрэлт хэрэгцээ мөн тогтмол өсөж байна. (БНХАУ-д зэсийг дэд бүтцийн төсөл, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон хэрэглээний барааны үйлдвэрүүд урьд өмнө байгаагүй хэмжээгээр хэрэглэж байна).

Өнөөдөр БНХАУ боловсруулсан зэсийн хувьд Чили улсын дараа орох дэлхийн хоёр дахь хамгийн том үйлдвэрлэгч болж байгаа бөгөөд зэсийн хэрэглээний хувьд дэлхийн зах зээлийн 20 хувийг эзэлж, дэлхийн хамгийн том хэрэглэгч болсон байна. 1999 оноос хойш БНХАУ-ын зэсийн дотоодын хэрэглээ жилд дунджаар бараг 20 хувиар өсөж ирсэн. Харин зэсийн дотоодын олборлолт болон боловсруулсан зэсийн үйлдвэрлэл жилд зөвхөн 4% ба 11%-иар тус тус өссөн. Үлдэж буй зэсийн эрэлт хэрэгцээг ихэвчлэн боловсруулсан зэсийн импортоор хангаж ирсэн болно.

Хүснэгт 19: БНХАУ-ын зэсийн үйлдвэр *(мянган тонноор)*

	2000	2001	2002	2003	2004
Зэсийн хэрэглээ	1,892	2,365	2,766	3,031	3,350
Олборлолт	613	605	597	607	625
Боловсруулалт	1,371	1,523	1,633	1,772	1,950
Зэсийн баяжмалын импорт, метрийн тонноор	544	677	673	801	-
Боловсруулсан зэсийн импорт, метрийн тонноор	687	835	1,181	1,357	-

Эх сурвалж: OECD - Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага, ICSG – Олон улсын зэс судлалын бүлэг

Сүүлийн 5 жилийн хугацаанд боловсруулсан зэсийн дотоодын үйлдвэрлэл тогтмол өсөж ирсэн ч БНХАУ нь импортын түүхий эдээс их хэмжээгээр хамаарсан хэвээр л байна. 2004 онд БНХАУ зэсийн баяжмалын эрэлт хэрэгцээгээ бараг нэг сая тонноор, катодын эрэлт хэрэгцээгээ 1.5 сая тонноор дутуу хангасан. Зэсийн хомсдолыг арилгах зорилгоор БНХАУ зэсийн баяжмалыг ихэвчлэн Австрали, Монгол, Перу, Чили болон Индонез зэрэг орнуудаас оруулж ирж байсан. Энэ хугацаанд Монгол улс БНХАУ-д зэсийн баяжмал нийлүүлж буй хоёр дахь хамгийн том экспортлогч болж байсан юм. Монгол улсын зэсийн экспортын хэмжээ нь тус улсын зэсийн баяжмалын үйлдвэрлэлтэй бараг тэнцэж байсан. Эрдэнэтийн зэсийн уурхайн үйлдвэрлэсэн зэсийн баяжмалын 85 гаруй хувь нь БНХАУ-д экспортолж байсан.

Хүснэгт 20: Зэсийн импорт *(мянган тонноор)*

	2000	2001	2002	2003	2004
Чили	617	694	459	822	-
Монгол	415	469	472	503	-
Австрали	230	514	319	363	-
Перу	74	149	309	395	-
Индонез	39	14	83	93	-
Бүгд	**1,375**	**1,840**	**1,642**	**2,176**	**-**

Эх сурвалж: WBMS – Металлын статистикийн дэлхийн бюро

Сүүлийн таван жилийн хугацаанд БНХАУ-ын зэсийн хэрэглээний жилийн өсөлтийн хувь ойролцоогоор 20 хувьтай байсан бөгөөд энэ нь дэлхийн зэсийн хэрэглээний өсөлтийн бараг ихэнхийг эзэлж байсан. БНХАУ нь зэсийг өндөр өртөгтэй орнуудын үйлдвэрлэлийг орлох зорилгоор экспортолдог төрөл бүрийн үйлдвэрийн бүтээгдэхүүнд ашигладаг. Анхан шатны хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт, түүнчлэн гадаад эх үүсвэрээс ирэх хөрөнгө оруулалт мөн өсөж байна. Ирэх жилүүдэд Хятадын зэсийн бүтээгдэхүүний экспорт өссөн хэвээр л байна гэж таамаглаж байгаа. Олон улсын зэсийн судалгааны бүлгээс гаргасан дүгнэлтийн дагуу зөвхөн 2005 онд БНХАУ-ын зэсийн эрэлт хэрэгцээ дор хаяж 8.4%-иар өсөж 3.6 сая тоннд хүрэх магадлалтай байна.

Алтны зах зээл

БНХАУ-ын алтны салбар нь ялимгүй өөр загвараар хөгжиж буй цорын ганц салбар юм. БНХАУ нь дэлхийн хамгийн том алт үйлдвэрлэгчдийн дунд тавдугаар байранд ордог. БНХАУ жилд ойролцоогоор 200 тонн алт үйлдвэрлэдэг.

БНХАУ-ын алтны эрэлт хэрэгцээ нь ихэвчлэн гоёл чимэглэлийн хэрэгцээнээс бүрддэг ба энэ нь 92%-ийг эзэлдэг. Аж үйлдвэрийн зориулалттай хэрэглээ маш бага бөгөөд жилд ойролцоогоор 10 тонн л байдаг.[14] Өнөөгийн байдлаар алтны орцтой аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ихэнх хувийг импортоор оруулж ирж байна. БНХАУ-д компьютер, электрон болон цахилгаан бараа үйлдвэрлэдэг асар их олон үйлдвэр байгаа ч эдгээр бүтээгдэхүүний нарийн эд сэлбэгийн ихэнх хувийг импортоор оруулж ирсэн хэвээр байна. Тийм учраас Хятадын аж үйлдвэрийн ажиглагчдын үзэж байгаагаар аж үйлдвэрийн зориулалттай алтны хэрэгцээ тодорхой хувиар цаашид өснө.

[14] GFMS (олон улсын консалтинг компани)-ийн судалгаа

Gold Fields Mineral Services компанийн үзэж байгаагаар Хятадын алтны зах зээлийг саяхан чөлөөлсөн явдал нь Хятадын алтны худалдааны загварт нилээд их хэмжээгээр нөлөөлөх болно. БНХАУ нь тухайн бүс нутагт алтны гол зах зээлүүдийн нэг болох магадлалтай юм. Өнөөдөр байгаа зарим жижиг үнийн ялгаа нь зах зээлийг чөлөөлснөөр ойрын ирээдүйд арилна. Сүүлийн хэдэн жилүүдэд БНХАУ-ын алтны импорт нилээд буурсан бөгөөд энэ нь зах зээлийг чөлөөлсөн үр дүнг хэсэгчлэн тусгаж байгаа юм.

2003 оны жилийн эцсийн байдлаар алтны 78%-ийг дотоодын уурхайнуудаас нийлүүлж, үлдсэн 22%-ийг импортоор эсвэл алтны хаягдлаар нийлүүлж байсан байна. Гэхдээ саяхан хийгдсэн юанийн[15] дахин үнэлгээ нь юанийн худалдан авах чадварыг дээшлүүлэх замаар БНХАУ-ын түүхий эдийн[16] эрэлт хэрэгцээг нэмэгдүүлнэ. Дотоодын валют чангарахад алтны импортын өртөг хямд тусах нь тодорхой юм.

Хүснэгт 21: БНХАУ-ын алтны зах зээл, 2000-2003 онууд

	2000	2001	2002	2003	2004
Нийлүүлэлт					
Бүх уурхай, метрийн тонн	172	193	202	213	
Гулдмай алтны импорт	130	126	95	32	
Хаягдал алтны нийлүүлэлт	16	16	6	-	
Нийт нийлүүлэлт	**321**	**336**	**317**	**273**	

Эх сурвалж: WBMS - Металлын статистикийн дэлхийн бюро

Өнгөт металлын аж үйлдвэр

БНХАУ нь дэлхийд хамгийн их төмрийн хүдрийн нөөцтэй орнуудын тоонд ордог. БНХАУ-ын албан ёсны статистикийн мэдээгээр тус улсад 1,940 төмрийн хүдрийн орд илэрсэн. 99 орд нь томд тооцогддог бөгөөд тэдгээрийн төмрийн хүдрийн нийт нөөц нь 100 сая гаруй тонноор хэмжигддэг. Ойролцоогоор 490 дунд хэмжээний орд байдаг бөгөөд тэдгээрийн нөөц нь 10-аас 100 сая тонны хооронд хэлбэлздэг. Үлдсэн ордууд нь жижигт тооцогддог. БНХАУ-ын төмрийн хүдрийн нийт нөөц нь дэлхийн батлагдсан нөөцийн 9.6%-тай тэнцдэг. Ийм их хэмжээний нөөц байгаа ч Хятадын төмрийн хүдэр нь дунджаар зөвхөн 33%-ийн буюу бага агуулгатай бөгөөд энэ нь гол хүндрэл болдог. Үүнээс гадна 1,700 гаруй ордыг ашиглахгүй байгаа учир нь хөнгөн цагаан болон фосфор зэрэг дагалдах элементүүдийн агуулга өндөр тул хүдрийн чанар доогуур байдаг. Төмрийн хүдрийн ордуудын ихэнх буюу ойролцоогоор 90% нь Хятадын зүүн болон зүүн хойд хэсгүүдэд оршдог (улс орны нийт нөөцийн 50% нь Хэбэй ба Ляонин гэдэг хоёр мужид оршдог).

Хүснэгт 22: БНХАУ-ын 2000-2005 онуудын хар төмөрлөгийн үйлдвэрлэл

	2000	2001	2002	2003	2004
Хар төмөрлөг, төмрийн агуулгаар, (мянган тонноор)	131,015	155,543	170,847	213,667	…

Эх сурвалж: www.adb.org

[15] Ренминби буюу БНХАУ-ын үндэсний валют (юань буюу Хятадын доллар гэж нэрлэгддэг)
[16] Металлын судалгаа, 167-р дугаар

Сүүлийн жилүүдэд БНХАУ хар төмөрлөгийн тэргүүлэх үйлдвэрлэгч болсон. Гэхдээ хүдрийн агуулга бага учраас металлын үйлдвэрлэл хамаагүй доод түвшинд байсан. 2003 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ ойролцоогоор 128 сая тонн хүдэр үйлдвэрлэж байсан бөгөөд энэ нь дэлхийн үйлдвэрлэлийн ойролцоогоор 13%-ийг эзэлж байсан. Улс орны хамгийн том ордуудыг олборлож буй 16 уурхайд хүдрийн нийт үйлдвэрлэлийн хагас хувь нь ногддог. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн үлдсэн хувийг 1,000 гаруй жижиг, дунд уурхайнууд үйлдвэрлэдэг бөгөөд тэд жилд дунджаар 50 мянгаас 1 сая хүртэл тонн хүдэр үйлдвэрлэдэг.

Хятадын өнгөт металлын үйлдвэрийн салбарт саяхан хийгдсэн бүтцийн өөрчлөн байгуулалтын үр дүнд үйл ажиллагааны орлого багатай олон жижиг уурхай хаагдахад хүрсэн. Энэ арга хэмжээний үр дагаврыг албан ёсоор хараахан дүгнээгүй байгаа боловч жижиг уурхайнууд хаагдсаны улмаас үүссэн хар төмөрлөгийн нийлүүлэлтийн хомсдолыг богино хугацаанд импортоор хангаж эхэлсэн. 2002 оноос хойш БНХАУ дэлхийд хар төмөрлөгийн хамгийн том импортлогч болон хувирсан. Үүнээс гадна металл ган бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ эрчимтэй өсөж байгаагаас Хятадын төмөрлөгийн үйлдвэрүүдийн ихэнх нь хар төмрийн хүдрийн хомсдолтой тулгарч байна. Хар төмөрлөгийн нөөцийн бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хар төмөрлөгийн томоохон компаниудын ихэнх нь хар төмөрлөгийн хамгийн том бэлтгэн нийлүүлэгч болох BHP Billiton (3 томоохон хар төмөрлөгийн компанитай нийтдээ 420 сая тонн хүдэр нийлүүлэх 12 жилийн гэрээтэй), Rio Tinto (400 сая тонн хүдэр нийлүүлэх 20 жилийн гэрээтэй), Fortescue Metals Group (нийтдээ 364 сая тонн хүдэр нийлүүлэх гэрээтэй) болон CVRD (135.7 сая тонн нийлүүлэх 20 жилийн гэрээтэй) зэрэг компаниудтай урт хугацааны гэрээнүүдийг байгуулаад байгаа.

Хятадын аж үйлдвэрийн ажиглагчдын үзэж байгаагаар ойрын ирээдүйд хар төмөрлөгийн импортын хэмжээ өсөх бөгөөд 2008 онд Бээжин хотноо болох Олимпийн тоглолт, мөн ашигт малтмалын эрэлт хэрэгцээнд нөлөөлж нэмэгдэнэ.

Бусад үндсэн металл

Цайр

Сүүлийн хоёр жилийн хугацаанд цайрын дэлхийн зах зээл дээр Хятадын хүчин зүйл асар их нөлөө үзүүлсэн. 2003 он хүртэл БНХАУ дэлхийд цайрын хамгийн том экспортлогч болж байсан бөгөөд дэлхийн зах зээлд 350 мянган тонн цайр нийлүүлж байсан. 2004 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ жилд 2,510 мянган тонн цайр үйлдвэрлэж, 2003 онтой харьцуулбал цайрын үйлдвэрлэл дор хаяж 9.9%-иар өссөн байна. Гэвч 2004 оноос эхлэн энэ байдал эрс өөрчлөгдөж эхэлсэн. 2004 онд Хятадын дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ хурдан өсөж БНХАУ-ын цайрын экспорт 20-с 28%-иар буурсан байна.

Хүснэгт 23: 2000-2004 онуудыг Хятадын цайрын зах зээл, (мянган тонноор)

	2000	2001	2002	2003	2004
Хэрэглээ	1,350	1,500	1,750	2,045	2,175
Олборлолт	1,780	1,572	1,624	1,637	1,750
Боловсруулалт	1,957	2,078	2,155	2,292	2,475
Импортын баяжмал	39	384	393	373	
Боловсруулсан цайрын импорт	17	22	69	136	
Экспорт баяжмал	70	7	2	0	
Экспорт боловсруулсан	561	544	472	451	

Эх сурвалж: ILZSG-Олон улсын цагаан тугалга болон цайр судлалын бүлэг

Дотоодын зах зээлийн цайрын эрэлт хэрэгцээ эрчимтэй өссөний улмаас цайрын импорт нилээд их хэмжээгээр нэмэгдэж, БНХАУ тус бүс нутагт цайрын хамгийн том импортлогчдын нэг болон хувирчээ. Цайрын эрэлт хэрэгцээний өсөлт нь Хятадын автомашин, барилга, гэр ахуйн цахилгаан тоноглол болон цайрыг үйлдвэрлэлд хэрэглэдэг бусад салбаруудын эрчимтэй өсөлттэй холбоотой юм. Үүнээс гадна цайрын эрэлт хэрэгцээ тууштай өсөж байхад дэлхийн цайрын үйлдвэрлэлийн 3%-ийг эзэлж, Хятадын цайрын хамгийн том үйлдвэрлэгчдийн нэг болох Жюжу хайлуулах үйлдвэр нь эрчим хүчний тасалдлаас болж 2005 оны нэгдүгээр улиралд үйлдвэрлэлээ гуравны нэгээр бууруулсан.

Олон улсын хар тугалга, цайрын судалгааны бүлэг (ILZSG)-ийн мэдээгээр 2005 онд цайрын эрэлт хэрэгцээ Хятадад 13%, АНУ-д 9.2%-иар тус тус өсөх тул цайрын дэлхийн хэрэглээ 6.4-өөс доошгүй хувиар өснө. Баруун Европын эрэлт хэрэгцээ дэлхийн хэрэглээний дөрөвний нэгтэй тэнцдэг бөгөөд зөвхөн 2.6%-иар нэмэгдэнэ гэж тооцоолж байна. 2005 онд Хятадын түүхэнд анх удаа цайрын импорт экспортоос давна. Цайрын экспорт үлэмж хэмжээгээр буурсан гол шалтгаан нь дотоодын ба дэлхийн зах зээлийн үнийн маш том ялгаатай холбоотой юм. Сүүлийн жилүүдэд цайрын дотоодын үнэ дотоодын зах зээл дээр үүссэн хомсдолоос болж Лондонгийн металлын биржийн спот үнээс хамаагүй өндөр байсан.

Өнөөдөр Хулудао өнгөт металлын бүлэг болон Чихонг Цайр зэрэг Хятадын цайрын томоохон үйлдвэрлэгчид нь уурхай байгуулах боломжтой цайрын ордуудыг идэвхтэй хайж байна. Хулудао өнгөт металлын бүлэг нь ОХУ-ын Алс Дорнодод хөрөнгө оруулалт хийж, энэ бүсэд цайрын том үйлдвэр байгуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ нь тус компанийн анхны гадаадын хөрөнгө оруулалт болох юм.

Олон улсын хар тугалга, цайрын судалгааны бүлэг (ILZSG)-ийн үзэж байгаагаар ирэх хоёр жилийн хугацаанд Хятадын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, цайрын импорт бага зэрэг буурна. БНХАУ-ын цайрын үйлдвэрлэл 2004 онд мэдрэгдэхүйц хэмжээгээр өссөн бөгөөд энэ өсөлт нь ирэх гурван жилийн хугацаанд хадгалагдана гэж таамаглаж байна.

Гянт болд

БНХАУ мөн гянт болдын томоохон үйлдвэрлэгч юм. Хятадын гянт болдын нөөц нь дэлхийн батлагдсан нөөцийн 60%-ийг эзэлдэг. Өнөөдрийн байдлаар БНХАУ-д ойролцоогоор 225 гянт болдын орд бүртгэгдсэн байна. Хятадын гянт болдын нөөцийн 70% нь Хунан, Жианжи, Гуандон, Фужиан ба Гуанжи зэрэг таван мужид байрладаг. Нөөцийн 40% нь штокверк хэлбэрийн (түүнчлэн грейсэн төрлийн) ордод тохиолддог, ойролцоогоор

35% нь скарны төрлийн ордод ба зөвхөн 20% нь судал хэлбэрийн ордод илэрдэг. Штокверк хэлбэрийн ордод тохиолддог нөөц нь бага агуулгатай (WO_3 0.2~1.0%) байдаг, харин скарн болон судал хэлбэрийн ордуудын хүдрийн нөөц нь харьцангуй өндөр агуулгатай (тус тус WO_3 0.3~2.0% ба 08~2.2%) байдаг. Гэхдээ скарн болон судал хэлбэрийн ордуудад WO_3 хэмжээ бага байдаг. Өнөөдөр гянт болдын хүдрийн 60%-ийг Шанжи мужид олборлож байна.

80-аад оны дунд үеэс 90-ээд оны сүүл хүртэлх хугацаанд БНХАУ нь дэлхийн зах зээл дээрх гянт болдын худалдааны загварыг тодорхойлж байсан гол оролцогч болж байсан. Энэ хугацаанд дэлхийн зах зээл дээр хятадын хямдхан гянт болдыг их хэмжээгээр тасралтгүй нийлүүлж байсны улмаас бараг бүх хятадын бус гянт болдын үйлдвэрлэгчид дампуурч, хаагдахад хүрсэн. Үүнээс гадна энэ байдал Хятадын гянт болдын салбарт ч сөргөөр нөлөөлсөн. Тэгээд 1999 онд БНХАУ гянт болдын салбарын өөрчлөн байгуулалтыг хийж эхэлсэн юм. Өөрчлөн байгуулалтын явцад хуучирсан технологиор ажиллаж байсан эсвэл байгаль орчныг их хэмжээгээр бохирдуулж байсан 50 гаруй үйлдвэрийг 2002 онд хаасан. Үүнээс гадна БНХАУ-ын Засгийн газар 2002 онд гянт болдын үйлдвэрлэлийн квотыг тогтоосон. Энэ арга хэмжээний дагуу зөвхөн 100-120 үйлдвэрт 22.5 мянган тонн хүдэр үйлдвэрлэх зөвшөөрөл олгосон байна. Ингэсний үр дүнд дотоодын зах зээл дээр гянт болдын үнэ нилээд их өссөн.

Үйлдвэрлэлийн квот тогтоохын зэрэгцээ Засгийн газар 2000 оноос хойш гянт болдын экспортыг үе шаттайгаар бууруулж эхэлсэн болно. 2004 онд гянт болдын экспортлогчдод олгож байсан бүх урамшууллыг бүрэн зогсоосон юм.

Хятадын өнгөт металлын нийгэмлэгийн үзэж байгаагаар ойрын ирээдүйд дэлхийн зах зээл дээрх гянт болдын эрэлт хэрэгцээ өндөр хэвээр байхаар байна.

зөвлөмж

Нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой уул уурхайн компаниудын үйл ажиллагааг дэмжсэн илүү тодорхой чиглэлээр тодорхойлогдсон арга хэмжээнүүдийг боловсруулах шаардлагатай байгаа нь тодорхой юм. Засгийн газрын өнөөгийн зорилтууд нь тодорхой бус байгаа болно.

Монгол улсын зэс болон хар төмөрлөгийн салбар нь нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоо хавьгүй их юм. Алт нь бэлэн мөнгөтэй дүйцдэг шинж чанартай тул алтыг тулгуурлан нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудал нь боломж муутай юм. Судал өнгөт металлын салбарын хөгжлийн өнөөгийн байдал нь эхний үе шатанд байгаа тул эдгээр салбаруудын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх тухай ярих нь хараахан эрт юм.

Үүний зэрэгцээ улс орны уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийг өсгөхийн тулд Засгийн газар нь чиглүүлсэн арга хэмжээг авахын зэрэгцээ ихээхэн хэмжээний хүчин чармайлтыг нэгэн зэрэг гаргах шаардлагатай байгаа болно.

Гол зөвлөмжүүд нь дараах зүйлсүүд болно. Үүнд:

- Хуулийн зүйл заалтыг дур зоргоор тайлбарлах, мөн хайгуулын болон олборлолтын лицензийг авах, төрөл бүрийн холбогдох зөвшөөрөл авах явцад дур зоргоор авирласан тохиолдолд орон нутгийн төрийн албан хаагчдад хариуцлага тооцох явдлыг мөрдүүлэх талаар тодорхой механизмыг нэвтрүүлэх буюу хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааг эрхлэн явуулахад орон нутгийн төр засгийн байгууллагуудаас зөвшөөрөл авдаг зарчмыг тогтоож буй Ашигт малтмалын тухай хуулийн заалтыг хүчингүй болгох.
- Эдийн засгийн чадавх багатай жилд 0.5-аас 5.0 кг алт олборлодог алтны компаниудыг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх талаарх хуулийн заалтуудыг чангатгах. Эдгээр компаниудын болон хууль бусаар алт олборлогчдын үйл ажиллагааны үр дүнд гарч буй нийгэм болон байгаль орчны хохирол нь хэт их өндөр юм.
- Нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцыг хөхиүлэн дэмжих тухай Засгийн газрын тусгай хөтөлбөр байх нь ашигтай байж болох юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд нийгэм эдийн засгийн томоохон ач холбогдолтой буюу ашиглалтад оруулах магадлал өндөртэй ордуудад хийх төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь ихээхэн ач холбогдолтой байх юм.
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь экспортын зориулалтаар нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой цөөхөн төрийн өмчит үйлдвэрийн газрын нэг юм. 2005 оны Засгийн газрын 48 дугаар тогтоолоор баталсан хувьчлах тухай тодорхой бус шийдвэрийн оронд стратегийн хөрөнгө оруулалтыг татах замаар Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг хувьчлах тусгай хөтөлбөрийг бий болгох нь зүйтэй юм.
- Оюу Толгой, Эрдэнэтийн үйлдвэрийн стратегийн хөгжлийг дэмжих тусгайлсан хөтөлбөрүүд байх нь ач холбогдолтой байж болох юм.
- Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тус үйлдвэрийн эрчим хүчний асуудлыг шийдэж өгөх шаардлагатай байна. Иймээс Эрдэнэт хотын дулааны цахилгаан станцын хувьчлалын асуудлыг Эрдэнэт үйлдвэрийн ашиг сонирхлыг харгалзан үзэж шийдвэрлэх нь зүйтэй юм.

- Хайгуулын ажлыг хөхиүлэн дэмжих, мөн олборлолтын компаниудад төслийн санхүүжилт олгох зорилгоор сайтар зохион байгуулагдсан санхүүгийн тогтолцоог байгуулах шаардлагатай байна. Иймээс Монгол улсын өнгөт металлын ирээдүйн хөгжилд металлын бирж болон өнгөт металл борлуулах захыг байгуулах нь ихээхэн ач холбогдолтой байх тул ийм биржийг байгуулах бололцоог судлах, хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.
- Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол банкны алтны нөөцийг нэмэгдүүлэх талаар хуулийн заалтыг оруулах шаардлагатай байгаа юм. Энэ арга хэмжээ нь цаашид Монгол улсад алтны дагалдах зах зээлийг хөгжүүлэх үндэс болох учиртай.

ХАВСРАЛТ 1: ЯРИЛЦЛАГА АВСАН ХҮМҮҮСИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

1. Паушок С.В., Алтан Дорнод компанийн гүйцэтгэх захирал.
2. Бертоли Ф., АНУ-ын ОУХА-ын “Эдийн Засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар” төслийн ахлагч
3. Жигачёв А.Л., Эрдэнэт Орос-Монголын хамтарсан үйлдвэрийн Бизнес, хөгжлийн газрын дарга
4. Идэш, Эрдэнэт Орос-Монголын хамтарсан үйлдвэрийн Хуулийн хэлтсийн дарга
5. Кислицын, Монголросцветмет нэгдлийн ерөнхий захирлын нэгдүгээр орлогч
6. Постовский В.В., Монголросцветмет нэгдлийн Төлөвлөлт, эдийн засгийн дүн шинжилгээний газрын дарга
7. Алгаа Н., Монголын үндэсний уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал
8. Цолмон, МонголВольфрам компанийн дэд захирал
9. Энхтуяа Н., Monpolymet компанийн үйлдвэрийн дарга
10. Авирмэд М., Дархан Төмөрлөгийн үйлдвэрийн ерөнхий инженер
11. Зоригт, ҮХЯ-ны Нэгдсэн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга
12. Энхтуяа Ц, Wagner Asia Equipment компанийн ерөнхий санхүүч
13. Магванжав, АМГТХЭГ-ын уул уурхайн газрын дарга
14. Цэгц Ц, АМГТХЭГ-ын уул уурхайн газрын ажилтан
15. Гансүх, Төрийн өмчийн хорооны хуулийн хэлтсийн дарга
16. Энхбаяр О., Ерөнхий сайдын зөвлөх
17. Мөнхбат Б., Marubeni компанийн зөвлөх асан
18. Дамдинжав, Эрдмин компанийн ерөнхий захирал
19. Төрбат Д., Mine Info компанийн Гүйцэтгэх захирал

ХАВСРАЛТ 2: АШИГЛАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, 2006-2008, Монгол улсын Засгийн газар;
2. Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл 2002-2006, Монгол улсын Засгийн газар;
3. Дагалдах зах зээл: зах зээлийн нөлөөлөл, Дэлхийн Алтны Зөвлөл, 2001;
4. Монгол улсын уул уурхайн салбар: Ирээдүйн хөгжил, Дэлхийн банк;
5. Хятад улсын алтны зах зээл: Шинэ эхлэл, GFMS консалтинг компани;
6. Хятадын мөнгөний зах зээлийн талаарх тайлан, GFMS консалтинг компани;
7. Эрдсийн зах зээлийн үнэлгээ – Өвөр Монголын өөртөө засах орны зүүн бүс, БНХАУ болон Монгол улсын хоорондох эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих тухай;
8. БНХАУ – жилийн эцсийн тайлан, 2004, Азийн хөгжлийн банк
9. Metal Bulletin Research сэтгүүл, дугаар 140-142, 167;
10. “Discover Mongolia – 2005” Уул уурхайн олон улсын хөрөнгө оруулагчдын бага хурал
11. Эрдэнэт уул уурхайн корпорацийг хөгжүүлэх стратегийн хөтөлбөр
12. Оюу Толгойн төсөл: Нэгдсэн хөгжлийн төлөвлөгөө, Айвенхоу Майнз
13. 2005, 2015 онууд дахь жоншны салбарын хөгжлийн хөтөлбөр: Монголросцветмет нэгдэл
14. Бизнес төлөвлөгөө, Эрдэс компани
15. Статистикийн эмхтгэл, 2000-2004, МҮСГ